

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол улсын газар нутгийг зохистой төлөвлөх, өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, бүртгэх, хяналт тавих, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой суурь харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Газрын тухай хууль тогтоомж

2.1.Газрын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хууль тогтоомжтой нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Дараах харилцааг энэ хуульд нийцүүлэн тусгайлсан хуулиар зохицуулна:

3.1.1.газрын бүрдэл хэсэг болох газрын хэвлий, түүний баялаг, ой, ус, усны нөөц, хийн мандлын агаар, ургамал, амьтан, байгалийн бусад баялгийг ашиглах, хамгаалах холбоотой харилцаа;

3.1.2.газрыг иргэний өмчлөлд шилжүүлэхтэй холбоотой харилцаа;

3.1.3.газрын үнэлгээ, татвар, төлбөр, хураамжтай холбоотой харилцаа;

3.1.4.газрын кадастр эрхлэхтэй холбоотой харилцаа;

3.1.5.кондоминиум олгох, ашиглахтай холбоотой харилцаа;

3.1.6.хот, суурины газрыг төлөвлөхтэй холбоотой харилцаа;

3.1.7.нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулж газрыг нөхөх олговортойгоор солих, эсхүл эргүүлэн авахтай холбоотой харилцаа.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."газар" гэж газрын бүрдэл хэсэг болох газрын хэвлий, түүний баялаг, хөрс, агаар, ой, ус, ургамал бүхий орон зайн давхаргыг;

4.1.2.“газар өмчлөх эрх” гэж газрыг хуулиар зөвшөөрсөн зориулалтаар эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг;

4.1.3.“газрын узуфрукт” гэж үр шимийг нь хүртэх, ашиг олох зорилгоор газрыг хязгаартай эзэмшиж, ашиглах эрхийг;

4.1.4.“төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх” гэж газрын гадаргуу дээр болон доор барилга байгууламж барих, уг барилга байгууламжаа болон барилга байгууламж барих эрхээ гуравдагч этгээдэд өвлүүлэх, барьцаалах, худалдах болон бусад хэлбэрээр захиран зарцуулах эрхтэйгээр тухайн газрыг өөрийн ашиглалтад шилжүүлэх эрхийг;

4.1.5.“сервитут” газрын эрхээ хэрэгжүүлэх зорилгоор газрын хязгаарлагдмал болон газар өмчлөх эрхийг хязгаарлах эрхийг;

4.1.6.“газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа” гэж газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын тогтвортой гол үзүүлэлтүүдийг хууль тогтоомжид заасан хугацаанд давтан тодорхойлж, улсын хяналтад авсан анхны үзүүлэлтүүдтэй харьцуулан газрын төлөв байдалд хийсэн чанарын дүгнэлтийг;

4.1.7.“газар зүйн нэр” гэж газрын гадаргуу дээрх байгалийн болон барьж байгуулсан объектуудыг өөр хооронд нь ялган таних зорилгоор тогтоосон нэрийг;

4.1.8.“бэлчээр” гэж мал, амьтан бэлчээх зориулалттай байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн ангилалд хамааруулсан газрыг.

5 дугаар зүйл.Төрөөс газрын талаар баримтлах зарчим

5.1.Төрөөс газрын талаар дараах зарчмыг баримтлана:

5.1.1.Газрын нэгдмэл байдлын зарчим:

5.1.1.1.Монгол Улсын газар нутаг салшгүй, бүрэн бүтэн, газрын сан нэгдмэл байх;

5.1.1.2.газрын нэгдмэл санг ил тод, цогц байдлаар удирдаж, зохион байгуулах;

5.1.1.3.газрын нэгдмэл сангийн бүрэн бүтэн байдал, хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд харшлах, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах үйл ажиллагаа явуулахгүй байх.

5.1.2.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх зарчим:

5.1.2.1.газрыг иргэн аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгохдоо хүртээмжтэй, тэгш байдал, шударга ёсыг хангах;

5.1.2.2.газрын талаарх мэдээлэл, газрын асуудал эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх;

5.1.2.3.газрын төлөв байдал, чанарт тогтмол хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь авч хэрэгжүүлж, мэдээлэх;

5.1.2.4.газар зохион байгуулах, төлөвлөх үйл ажиллагаа иж бүрэн, ил тод байх;

5.1.2.5.газрын хохирол, нөхөн сэргээлтийн тайлан, мэдээ ил тод байх;

5.1.2.6.газрын бүртгэл ил тод байх.

5.1.3.газрыг хамгаалах, нөхөн сэргээх, хохирол төлүүлэх зарчим:

5.1.3.1.байгалийн нөөцийн даац, чадавх болон иргэдийн эрэлт хэрэгцээг үндэслэн салбар дундын зохицуулалттай иргэн, хуулийн этгээдийн оролцоог хангасан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газрын эрхийг олгох;

5.1.3.2.газар төрийн хяналт, хамгаалалтад байх;

5.1.3.3.газар нь үнэлгээ, төлбөр, хураамжтай байх;

5.1.3.4.газрыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу үндсэн зориулалтаар нь үр ашигтай, зохистой эзэмших, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;

5.1.3.5.газарт учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх.

6 дугаар зүйл.Төрөөс газрын талаар баримтлах бодлого

6.1.Монгол Улс газрын талаар төрөөс баримтлах бодлоготой байна.

6.2.Газрын талаар төрөөс баримтлах бодлого нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан баримт бичгийн холбогдох хэсэгт тусгагдах бөгөөд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан Улсын Их Хурал батална.

6.3.Газрын талаар төрөөс баримтлах бодлогод дараах асуудлыг тусгана:

6.3.1.Монгол Улсын газар нутаг бүрэн бүтэн, хил хязгаар, экологи, хүнсний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх асуудал;

6.3.2.газрыг үр ашигтай төлөвлөхөд салбар дундын зохицуулалтыг хангах замаар хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгмийн харилцан уялдаатай тогтвортой газар ашиглалтыг төлөвлөх асуудал;

6.3.3.бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлэх асуудал;

6.3.4.газрыг иргэн, хуулийн этгээдэд шилжүүлэх эрхийн төрлийг оновчтой тогтоох замаар газар, үл хөдлөх хөрөнгийн эрх, хөрөнгө оруулалтын баталгааг хангаж эдийн засгийн хөгжлийг дэмжих асуудал ;

6.3.5.газрыг үнэлж газрын татвар, төлбөрийг оновчтой тогтоох асуудал;

6.3.6.газрын маргаан зөрчлийг бууруулах, шийдвэрлэх тогтолцооны асуудал;

6.3.7.газрын эдийн засгийн харилцаа, санхүүжилтийн тогтолцооны асуудал;

6.3.8.газрын төлөв байдал, чанарыг хамгаалах, нөхөн сэргээх, биологийн нөөцийг тогтвортой ашиглах зорилгоор байгалийн болон хүний үйл ажиллагааны нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих тогтолцооны асуудал;

6.3.9.газрын нэгдмэл сангийн удирдлагын тогтолцооны асуудал;

6.3.10.газар зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удиргах байгууллагууд болон мэргэжлийн төрийн захиргааны байгууллага, албан хаагчийн үүрэг оролцоо, зааг ялгааны асуудал;

6.3.11.газар зохион байгуулалтад орчин үеийн техник технологи, засаглалыг дэвшлийг нэвтрүүлэх асуудал ;

6.3.12.салбарын хүний нөөцийн асуудал.

6.4.Газрын талаар төрөөс баримтлах бодлогыг үе шаттайгаар, арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

7 дугаар зүйл.Монгол Улсын газар нутгийн газар зүйн нэр

7.1.Монгол Улсын газар нутаг газар зүйн нэр, газрын зурагтай байна.

7.2.Монгол Улсын газар зүйн нэрийг Улсын Их Хурал батална.

7.3.Газар зүйн нэрийг тодорхойлох, тэдгээрт орсон өөрчлөлтийг тусгах, хөтлөх асуудлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхэлнэ.

7.4.Хилийн цэс, газар зүйн нэр, зургийг хадгалах, ашиглах, тэдгээрт орсон өөрчлөлтийг тусгах, хөтлөх журмыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

7.5.Албан ёсны баримт бичиг болон арга хэмжээнд газар зүйн давхар нэр хэрэглэх, газар зүйн нэрийг Монгол хэлнээс бусад хэлээр орчуулах, бусад хэлний дуудлагаар галиглан бичихийг хориглоно.

8 дугаар зүйл.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэс тогтоох

8.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хилийн цэс, түүнийг харуулсан зураг, бүртгэлтэй байна.

8.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг Улсын Их Хурал батална.

8.3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, бүртгэх асуудлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхэлнэ.

8.4.Дараах тохиолдолд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөх буюу тодотгоно:

8.4.1.эрх бүхий байгууллага засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, тэдгээрийн хилийн цэсийг шинэчлэн тогтоох, шинээр засаг захиргааны нэгж байгуулах шийдвэр гаргасан;

8.4.2.улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон хүн амын нутагшил, суурьшлын ерөнхий төсөл, хөтөлбөрт нутаг дэвсгэрийн эдэлбэр газрын бүтцийг оновчтой болгох, газрын нөөц чадавх хангалтгүй, эдийн засаг, экологийн хүндрэлтэй нөхцөлийг харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг татан буулгах, нэгтгэхээр шийдвэрлэсэн;

8.4.3.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар нутаг нь зэргэлдээх эдэлбэр газарт байршсан болон засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийг дамнасан, төрийн болон нийгэм, аж ахуй, соёлын үйлчилгээг иргэд, олон нийтэд ойртуулах хүндрэлтэй байдлыг арилгах зорилгоор эрх бүхий байгууллагаас газар зохион байгуулалтын зураг төсөл боловсруулах талаар шийдвэр гаргасан;

8.4.4.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, тэдгээрт өөрчлөлт оруулах, тодотгох талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас санал гаргасан;

8.4.5.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хооронд хилийн цэсийн маргаан үүссэн.

8.5.Нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөх, тодотгохтой холбоотой ажлыг газар зохион байгуулалт хийх журмаар зохицуулна.

8.6.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тодотгох, өөрчлөх саналыг мэргэжлийн комиссын дүгнэлтийн хамт Засгийн газарт өргөн барина.

8.7.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэгийг тогтоохдоо байгалийн болон хүний гараар бүтээсэн хөдөлшгүй объектуудыг сонгон тэдгээрийн байршлыг газар зүйн солбицлоор баталгаажуулна.

8.8.Эргэлтийн цэгийг холбосон хилийн шугамыг голоор, жалгаар, замаар, нуруулдах зэргээр тодорхой чиглэл заагаагүй нөхцөлд шулуун шугамаар холбож тогтооно.

8.9.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн шугамаас хоёр тийш 5 км хүртэлх зайг хилийн цэсийн бүс нутаг бөгөөд тус бүс нутагт зөвхөн уламжлалт аргаар мал маллаж буй иргэдийн мал бэлчээрлэх, худаг, уст цэг ашиглах эрх нь тухайн хилийн цэсээр хязгаарлагдахгүй.

9 дүгээр зүйл. Баг, хорооны нутаг дэвсгэрийн зааг

9.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13.4, 13.5-д заасны дагуу баг, хорооны нутаг дэвсгэрийн заагийг тогтоох, бүртгэх асуудлыг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

9.2.Баг, хорооны нутаг дэвсгэрийн заагийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 14.5-т зааснаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

9.3.Баг, хорооны нутаг дэвсгэрийн заагийг тогтоох журмыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

9.4.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь баг, хороог өөрчлөх, нутаг дэвсгэрийн заагийг тогтоох үйл ажиллагаанд хяналт тавьж, дүгнэлт гаргана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГАЗРЫН НЭГДМЭЛ САН, ТҮҮНИЙ УДИРДЛАГА

10 дугаар зүйл.Газрын нэгдмэл сан, түүний удирдлагын нэгдмэл байдал

10.1.Монгол Улсын хилийн доторх нийт газар нь өмчийн төрөл хэлбэрээс үл хамааран Монгол Улсын газрын нэгдмэл санг бүрдүүлнэ.

10.2.Монгол Улсад газрын нэгдмэл сангийн удирдлага нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газрын эрх, газар ашиглах зориулалтаас үл хамааран нэгдмэл байх бөгөөд удирдлагын тогтолцоог энэ хуулиар тогтооно.

11 дүгээр зүйл.Газрын нэгдмэл сангийн ангилал

11.1.Газрын нэгдмэл санг газар ашиглах зориулалт, хэрэгцээг харгалзан дараах байдлаар ангилна:

- 11.1.1.хөдөө аж ахуйн газар;
- 11.1.2.хот, тосгон, бусад суурины эдэлбэр газар;
- 11.1.3.зам, шугам сүлжээний газар;
- 11.1.4.ойн сан бүхий газар;
- 11.1.5.усны сан бүхий газар.

12 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн газар

12.1.Хөдөө аж ахуйн газарт дараах газар хамаарна:

- 12.1.1.бэлчээрийн газар;
- 12.1.2.хадлангийн газар;
- 12.1.3.тариалангийн газар;
- 12.1.4.хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар;
- 12.1.5.хад асга, элсэн манхан, ургамлын бүрхэвчгүй газар.

13 дугаар зүйл.Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газар

13.1.Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газарт хот, тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр газар, инженерийн дэд бүтэц, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийн газар, нийтийн эдэлбэрийн газар болон цаашид тэлж хөгжих нөөц газар хамаарна.

13.2.Нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна.

13.3. Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газар нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрээс хил заагаар хязгаарлагдана.

14 дүгээр зүйл. Зам, шугам сүлжээний газар

14.1.Зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, хий, газрын тос, ус хангамж, ариутгах татуурга, зам, замын зурвас газар, тээвэр, холбоо, мэдээлэл зэрэг зориулалтаар хот, тосгон, бусад суурины эдэлбэр газрын гадна олгогдсон инженерийн шугам сүлжээ, эх үүсвэр, барилга байгууламжийн доорх газар хамаарна.

15 дугаар зүйл.Ойн сан бүхий газар

15.1.Ойн сан бүхий газарт дараах газар хамаарна:

- 15.1.1.ой мод бүхий газар;
- 15.1.2.ойн цоорхой, зурвас газар;
- 15.1.3.бут, сөөг бүхий газар;

- 15.1.4.загтай газар;
- 15.1.5.мод үржүүлгийн газар;
- 15.1.6.ой доторх модыг нь огтолсон талбай.

16 дугаар зүйл.Усны сан бүхий газар

16.1.Усны сан бүхий газарт дараах газар хамаарна:

- 16.1.1.нуур, цөөрөм, тойром;
- 16.1.2.мөрөн гол;
- 16.1.3.горхи, булаг, шанд, рашаан;
- 16.1.4.мөстөл, мөсөн гол;
- 16.1.5.усны урсгал шургасан хуурай сайр;
- 16.1.6.намаг;
- 16.1.7.усан сан;
- 16.1.8.уст цэгийн доорх газар.

17 дугаар зүйл.Газрын нэгдмэл сангийн ангилал тогтоох, газрыг ангилал хооронд шилжүүлэх

17.1.Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллыг энэ хуулиар тогтооно.

17.2. Энэ хуулийн 11.1-д заасан газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын газрыг хоорондоо хил заагтай, бүртгэлтэй байна.

17.3. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрын байршил, хил зааг, хэмжээг тогтоох, газрыг ангилал хооронд шилжүүлэх асуудлыг улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

17.4. Газрын нэгдмэл сангийн тооллого, тоо бүртгэлийн асуудлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газраас баталсан журмын дагуу цахимаар эрхэлнэ.

18 дугаар зүйл.Газар ашиглах зориулалт

18.1.Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын хүрээнд газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн газрыг ашиглах зориулалтаар нь төлөвлөж, иргэн, хуулийн этгээдэд энэ хуульд заасны дагуу өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулна.

18.2.Энэ хуулийн 18.1-д зааснаас бусад тохиолдолд газар ашиглах зориулалтыг газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, холбогдох бусад хууль тогтоомж, норм, дүрэмд нийцүүлэн өөрчилж болно.

18.3.Газрын зориулалтыг дараах тохиолдолд өөрчлөхийг хориглоно.

18.3.1.хот, тосгон, бусад суурины эдэлбэр газар дахь нийтийн эдэлбэр газрын зам талбай, ногоон байгууламж, цэцэрлэг, явган хүний зам, нэвтэрч гарах болон дайран өнгөрөх газар, хүүхдийн тоглоомын талбай, сүүдрэвч, авто зогсоолын

газар, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг өөрчлөх, өөр зориулалтаар ашиглах;

18.3.2.нийтээр ашиглах бэлчээрийн газарт өвөлжөө, хаваржааны барилга байгууламж барих, ашиглах;

18.3.3. тариаланд тохиромжтой болох нь судалгаагаар тогтоогдсон атар газрыг хөдөө аж ахуй, ойн аж ахуйгаас бусад зориулалтаар ашиглах;

18.3.4.ойн сан бүхий газар, гол, мөрний урсац бүрэлдэх эх газрыг уул уурхайн хайгуул, ашиглалтын зориулалтаар ашиглах;

18.3.5.бүх төрлийн хамгаалалтын бүсэд хамаарах газрыг мал бэлчээх, хадлан хадахаас бусад зориулалтаар ашиглах;

18.3.6.улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд уламжлалт мал аж ахуй эрхлэх, хадлан хадах, зам гүүр, эрчим хүч, харилцаа холбооны шугам байгуулах, засварлах, эрдэм шинжилгээний ажил хийх, ойн аж ахуйн арга хэмжээ хэрэгжүүлэх, байгалийн аялал хийх, түр буудаллах, отоглохоос бусад зориулалтаар ашиглах;

18.3.7.оршуулгын газрыг ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулахаас бусад зориулалтаар ашиглах.

19 дүгээр зүйл.Тусгай хэрэгцээний газар

19.1.Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Газрыг дараах зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авч болно:

19.1.1.улсын тусгай хамгаалалттай газар;

19.1.2.улсын хилийн зурвас газар;

19.1.3.улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар;

19.1.4.гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар;

19.1.5.шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын газар /полигон/;

19.1.6.аймаг дундын отрын бэлчээр;

19.1.7.улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай;

19.1.8.газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу ашиглах газрын тосны гэрээт талбай;

19.1.9.чөлөөт бүсийн газар;

19.1.10.цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар;

19.1.11.хилийн боомтын бүс;

19.1.12.үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, инженерийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар;

19.1.13.аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар;

19.1.14.дүйцүүлэн хамгаалах газар;

19.1.15.цэвэр усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, хүн амын ус хангамжийн аюулгүй байдлыг хангах зориулалтын газар;

19.1.16.тариаланд тохиромжтой атар газар;

19.1.17.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газар.

19.2.Орон нутгийн хэмжээний томоохон бүтээн байгуулалт, инженерийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар болон усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, хүн амын ус хангамжийн аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий газар, сум дундын отрын бэлчээр, хадлангийн талбайн зориулалтаар газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болно.

19.3.Газрын нэгдмэл сангийн аль ч ангиллын газраас улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болно.

20 дугаар зүйл.Газрыг тусгай хэрэгцээнд авах, гаргах

20.1.Энэ хуулийн 19.1.1-19.1.4, 19.1.9-19.1.11, 19.1.14, 19.1.17-д заасан зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, хил заагийг тогтоох асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

20.2.Энэ хуулийн 19.1.5-19.1.8, 19.1.12, 19.1.13, 19.1.15, 19.1.16-д заасан газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, хил заагийг тогтоох, энэ хуулийн 19.1-д заасан улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглах журмыг батлах, эрх бүхий байгууллагын мэдэлд шилжүүлэх асуудлыг Монгол Улсын Засгийн газар шийдвэрлэнэ.

20.3.Газрыг энэ хуулийн 19.3-т зааснаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, гаргах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

20.4.Газрыг дараах үндэслэлээр улсын тусгай хэрэгцээнд авна:

20.4.1.улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан;

20.4.2.үндэсний болон салбар, салбар хоорондын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан;

20.4.3.Улсын Их Хурал болон Засгийн газрын шийдвэрт тусгасан.

20.5.Газрыг дараах үндэслэлээр хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь тусгай хэрэгцээнээс гаргаж болно:

20.5.1.тусгай хэрэгцээний газрын хил зааг, талбайн хэмжээнд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн;

20.5.2.газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хэсэгчлэн болон бүхэлд нь буцаасан, хугацаа дуусгавар болсон, гэрээг цуцалсан;

20.5.3.үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, төсөл, хөтөлбөр хэрэгжсэн.

20.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл холбогдох төрийн захиргааны төв байгууллага газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах хүсэлтийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

20.7.Улсын тусгай хэрэгцээний газрын бүртгэл, мэдээллийн санг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхэлж, газрыг тусгай хэрэгцээнд авах, гаргахад дүгнэлт гаргана.

20.8.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, гаргахдаа газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас дүгнэлт гаргуулна.

20.9.Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах шийдвэрт тухайн газрын

удирдлагыг хэрэгжүүлэх этгээд, тухайн газарт мөрдөх дэглэм, горимыг тодорхой заана.

20.10.Улсын тусгай хэрэгцээний газарт газар зохион байгуулалт хийх, газрыг тусгай хэрэгцээнд авах, гаргах, журмыг Засгийн газар батална.

21 дүгээр зүйл.Газрын нэгдмэл сангийн удирдлага

21.1.Газрын нэгдмэл сангийн удирдлагыг газар зохион байгуулалтын арга хэмжээгээр хэрэгжүүлнэ.

21.2.Газрын нэгдмэл сангийн удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн байгууллагууд дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.2.1.Улсын Их Хурал төрөөс газрын талаар баримтлах бодлогыг тодорхойлно;

21.2.2. Засгийн газар газрын харилцаанд төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж, газрын нэгдмэл сангийн удирдлагыг хэрэгжүүлэгч төрийн өмчит нийтийн эрх зүйн этгээдийг нийтлэг зорилтод нэгтгэн чиглүүлж, салбар хоорондын уялдааг хангаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана;

21.2.3.газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрөөс газрын талаар баримтлах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулна.

21.2.4.байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүрээлэн буй орчин, биологийн төрөл зүйлийг хадгалах, хамгаалах, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн газрын харилцааг зохицуулах чиглэлээр газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллана;

21.2.5.хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь байгалийн бүс бүслүүрийн онцлог, байгаль-хөдөө аж ахуйн бүсийн экологи-аж ахуйн чадавхад нийцүүлэн мал маллагаа, хадлан, тариалан, бэлчээрийн газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллана;

21.2.6.уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газрын хэвлийн баялаг, эрдэс түүхий эдийг зохистой ашиглах бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх, газрын хэвлийг ашиглах, геологийн судалгаа хийх чиглэлээр газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллана;

21.2.7.бусад төрийн захиргааны төв байгууллага эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар газрыг ашиглах горим, хамгаалалтын зурвастай холбоотой журам, норм, дүрмийг боловсруулах чиглэлээр газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллана;

21.2.8.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газрын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газар болон газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, энэ хуулийн 22-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж, аймаг, нийслэлийн Засаг дарга болон улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг эзэмшиж буй

төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай газрын удирдлагын гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана;

21.2.9.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэртээ төрөөс газрын талаар баримтлах бодлого, газрын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, тухайн шатны Засаг даргын боловсруулсан ерөнхий болон жилийн төлөвлөгөөг хянан баталж, газар зохион байгуулалтын улсын ерөнхий болон жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавина;

21.2.10.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нутаг дэвсгэртээ газрын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, тухайн шатны газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах бөгөөд газар зохион байгуулалтын улсын ерөнхий болон жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, газар хамгаалах, нөхөн сэргээх, газар чөлөөлөх асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд эрхэлнэ.

22 дугаар зүйл. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо

22.1.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх бөгөөд аймаг, нийслэл, дүүрэгт газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, суманд газрын даамалтай байна.

22.2.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь аймаг, нийслэлийн газрын ерөнхий даамал, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь улсын газрын ерөнхий даамал байна.

22.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

22.4.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн сумын газрын даамал, дүүргийн газрын албаны даргыг томилж, чөлөөлнө.

23 дугаар зүйл. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

23.1.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газрын харилцааны талаар энэ хуулийн 21.2.8-д зааснаас гадна дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.1.1.газрын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх;

23.1.2.газрыг бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах;

23.1.3.бүх шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг мэргэжлийн зөвлөмж, чиглэлээр, энэ хуулийн 22.1-д заасан байгууллага, албан тушаалтныг мэргэжлийн удирдлагаар хангах;

23.1.4.газар зохион байгуулалт, газар хамгаалах, нөхөн сэргээх, үйл ажиллагаанд хяналт тавих;

23.1.5.газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг байгуулж, нийтэд мэдээллээр үйлчлэх;

23.1.6.газрын төлөв байдал, чанарыг тодорхойлох, түүний өөрчлөлтийг ажиглах, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах хяналт-шинжилгээний улсын сүлжээг ажиллуулах;

23.1.7.газрын асуудлаар ирсэн өргөдөл, гомдол, хууль зөрчсөн үйлдлийн талаарх мэдээллийг хууль тогтоомжийн хүрээнд хянан шийдвэрлэх;

23.1.8.газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт өгөх.

23.2.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд энэхүү төсөв нь уг байгууллага чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

24 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, дүүргийн газрын алба, сумын газрын даамлын чиг үүрэг

24.1.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.1.1.аймаг, нийслэлийн газрын кадастр, газрын мэдээллийн санг зохих журмын дагуу эрхлэх, олон нийтэд үйлчилгээ үзүүлэх;

24.1.2.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг боловсруулахад иргэдийн оролцоог хангах, төлөвлөгөөг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах, хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах;

24.1.3.газрын нэгдмэл сангийн тайлан гаргаж тухайн шатны Засаг даргад тайлагнах;

24.1.4.дүүргийн газрын албаны дарга, албан хаагч, сумын газрын даамлыг томилох;

24.1.5.иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийн дагуу газрын эрх олгох, газар ашиглуулах гэрээ байгуулах шийдвэр гаргаж, дүүргийн газрын алба, сумын даамалд гэрээ байгуулах зөвшөөрөл олгох;

24.1.6.газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын ялагчтай гэрээ байгуулж, хууль тогтоомжийн дагуу газрын төлбөрийг ногдуулж, газрыг баримтаар хүлээлгэн өгөх;

24.1.7.орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан, тусгай хэрэгцээнээс гаргасан газрын хэмжээ, байршил, эргэлтийн цэгүүдийн солбицлыг газар дээр нь тогтоож, холбогдох мэдээллийг газрын мэдээллийн санд бүртгэх.

24.2.Дүүргийн газрын алба, сумын даамал энэ хуулийн 23.1.6 болон бусад холбогдох зүйлд зааснаас гадна дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.2.1.газрын нэгдмэл сангийн тайланг гаргаж тухайн шатны Засаг даргад тайлагнах;

24.2.2. аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрийг үндэслэн иргэн, хуулийн этгээдэд газрын эрх олгох, газар ашиглуулах гэрээ байгуулж, газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулж, газрыг баримтаар хүлээлгэн өгөх;

24.2.3. тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт эрх бүхий этгээдийн шийдвэрээр газрын эрх олгосон, гэрээгээр ашиглуулах газрын хэмжээ, байршил, эргэлтийн цэгийн солбицлыг газар дээр нь тогтоож, тухайн эдлэн газрын талаарх мэдээллийг тухай бүр газрын мэдээллийн санд оруулах;

24.2.4. сум, дүүргийн газрын мэдээллийн санг зохих журмын дагуу эрхэлж, нийтэд мэдээллийн үйлчилгээ үзүүлэх.

24.3. Аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сумын газрын даамлын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга дэмжлэг үзүүлнэ.

24.4. Сумын хүн ам, газар зүйн байршлыг харгалзан сумын газрын даамлын орон тооны жишгийг Засгийн газар тогтооно.

25 дугаар зүйл. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем

25.1. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем /цаашид “газрын удирдлагын цахим систем” гэх/-ийг ажиллуулна.

25.2. “Газрын удирдлагын цахим систем” нь дараах дэд сан, системтэй байна:

25.5.1. газар, байгалийн нөөцийн мэдээллийн;

25.5.2. газар зохион байгуулалтын төлөвлөгөөний;

25.5.3. биржийн цахим;

25.5.4. кадастрын;

25.5.5. газрын үнэлгээ, татвар, төлбөрийн;

25.5.6. газрын төлөв байдал, чанарын мониторингийн;

25.5.7. хаягийн.

25.3. “Газрын удирдлагын цахим систем” нь байрлалд суурилсан, Геодези, зураг зүйн тухай хуульд заасан байрлал, өндрийн нэгдсэн тогтолцоонд хийгдсэн, цахим байна.

25.4. Газрын удирдлагын цахим систем нь төрийн өмч байна.

25.5. Газрын удирдлагын цахим системийн цахим сүлжээ үрэгдэх, устгагдахаас бүрэн хамгаалагдсан байх бөгөөд улсын онцгой объектын зэрэглэлтэй байна.

25.6. Газрын удирдлагын цахим системийг улсын хэмжээнд үүсгэх, түүний тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, сүлжээний зохион байгуулалт, найдвартай байдлыг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

25.7. Газрын удирдлагын цахим систем нь төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох боломжтой байх бөгөөд төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад дундын мэдээллийн сан үүсгэн ажиллуулна.

25.8.Энэ хуульд заасан төрийн байгууллагын эрх бүхий субъект нь газрын эрх олгох болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг зөвхөн Газрын удирдлагын цахим системээр дамжуулан зохион байгуулна.

25.9.Газрын удирдлагын цахим систем нь дундын мэдээллийн сангаар дамжуулан Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн, Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай газрын үнэлгээ, татвар, төлбөрийн, Ашигт малтмалын байгууллагатай ашигт малтмалын лиценз олгох чиглэлээр өдөр тутам мэдээлэл солилцох үйл ажиллагааг хангаж ажиллана.

25.10.Энэ хуулийн 25.1-т заасан цахим системийн үйл ажиллагаа болон мэдээлэл нь улсын хэмжээнд нэгдсэн, нийтэд нээлттэй ил тод байна.

25.11.Цахим мэдээллийн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөгжүүлэх, албан хаагчдыг мэргэшүүлэх сургалттай холбоотой үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгана.

25.12.Газрын удирдлагын цахим систем нь иргэд, нутгийн өөрийн удирдлага болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудыг аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн байгууллага, сумын газрын даамлын үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна.

26 дугаар зүйл. Газрын удирдлагын цахим системд тавигдах шаардлага

26.1.Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн систем нь дараах шаардлагыг хангасан байна:

26.1.1.бүх шатны газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж, иргэдийг ил тод, нээлттэй ашиглах боломжоор хангасан байх;

26.1.2.газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг боловсруулахад иргэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран санал өгөх, энэ хуульд заасан эрх бүхий этгээдийн баталсан төлөвлөгөөнөөс сонголт хийж хүсэлтээ цахимаар гаргах боломжоор хангасан байх;

26.1.3.салбаруудын төлөвлөлтийг өөр хоорондоо уялдсан, давхцаагүй хийхийг системээр хяналт тавих нөхцлийг бүрдүүлсэн байх;

26.1.4.энэ хуульд заасан газрын эрхийг зөвхөн тухайн жилийн төлөвлөгөөний дагуу газрыг шилжүүлж байх нөхцлийг бүрдүүлсэн байх.

26.2.Биржийн цахим систем нь нь дараах шаардлагыг хангасан байна:

26.2.1.газрыг иргэдэд олгох үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу нээлттэй ил тод зохион байгуулж, иргэн, хуулийн этгээд орон зай, цаг хугацаанаас үл хамааран оролцох, өрсөлдөөнийг дэмжих, нөхцлийг бүрдүүлсэн байх;

26.2.2.иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэсэн байх;

26.2.3.Газрын зах зээлийн үнийн мэдээллийг цуглуулах боломжтой байх;

26.2.4.Газрын эрхийн шилжилт хөдөлгөөн, газар, үл хөдлөх эд хөрөнгийн зуучлал, зар мэдээллийн үйл ажиллагааг зохицуулах боломжтой байх.

26.3.Кадастрын цахим систем нь нь дараах шаардлагыг хангасан байна:

26.3.1.иргэн, хуулийн этгээдийг газрын эрх авах хүсэлтээ цахимаар гаргах нөхцлийг бүрдүүлсэн байх;

26.3.2.иргэдийн газрын эрх авахаар гаргасан хүсэлтийг шийдвэрлэх дэс дараалсан үйл ажиллагааг цахимжуулж, шат дамжлагыг арилгасан байх;

26.3.3.хүсэлт, шийдвэрлэлтийн явцыг иргэд өөрсдөө цахимаар хянах боломжтой байх;

26.3.4.Иргэн, хуулийн этгээд нь Газрын удирдлагын цахим системд баталгаажсан газрын эрхтэй холбоотой лавлагаа, мэдээлэл, тодорхойлтыг цахимаар авах боломжтой байх;

26.3.5.Эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй дундын мэдээллийн сангаар холбогдсон байх;

26.3.6.газрын эрхийн гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг болон газрын хянан баталгааны дүгнэлтийг нууцлал бүхий кодчилолтойгоор хэвлэх боломжийг бүрдүүлсэн байх;

26.3.7.Нэгж талбарт суурилсан үл хөдлөх, эд, хөрөнгийн нэгж талбарт суурилсан байх.

26.4.Газрын үнэлгээ, татвар, төлбөрийн систем нь дараах шаардлагыг хангасан байна:

26.4.1.нэгж талбар бүрээр газрын зах зээлийн үнэ, үнэлгээг хөтлөх, иргэн, хуулийн этгээдэд газрын төлбөр, татварыг ногдуулах, төлөх боломжийг бүрдүүлсэн байх.

26.4.2.газрын зах зээлийн үнэлгээг нэгж талбар бүрээр нөлөөлж буй хүчин зүйлийг харгалзан системээс хийдэг боломжтой байх;

26.4.3.татварын ерөнхий газартай дундын мэдээллийн сангаар холбогдсон байх;

26.4.4.Газрын төлбөр, татвар, үйлчилгээний хураамж болон улсын тэмдэгтийн хураамжийг цахимаар авах, төлөх, хянах боломжийг бүрдүүлсэн байх;

26.4.5.Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт, лавлагааг цахимаар авах боломжтой байх;

26.4.6.газар, үл хөдлөх, эд, хөрөнгийн үнэлгээг тооцоолох боломжтой байх.

26.5.Газрын төлөв байдал, чанарын мониторингийн систем нь дараах шаардлагыг хангасан байна:

26.5.1.Монгол орны газар нутгийн төлөв байдал, чанарын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлсэн байх;

26.5.2.газрын нэгдмэл сангийн ангилал бүрээр газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээ байгуулагдаж, мэдээлэл нь ил тод нээлттэй байх;

26.5.3.зайнаас тандах технологийг ашиглах боломжтой байх;

26.5.4.улсын хэмжээнд газрын төлөв байдал, чанарыг хянаж дүн шинжилгээ хийх, газрын доройтлыг тодорхойлох, бууруулах боломжийн талаар зөвлөмж гаргах боломжийг бүрдүүлсэн байх.

26.6.Хаягийн сан нь систем нь дараах шаардлагыг хангасан байна:

26.6.1.улсын хэмжээнд төлөвлөлт, бүртгэлийн шатнаас эхлэн газар, үл хөдлөх, эд, хөрөнгөнд системээс хаяг олгодог онлайн систем байх;

26.6.2.энэ хуульд заасны дагуу газрын эрх үүсэх, үл хөдлөх, эд, хөрөнгийг улсын комисст хүлээн авснаар хаягийг кадастрын системд бүртгэдэг байх;

26.6.3.хаягийн өөрчлөлт, мэдээлэл нь олон нийтэд нээлттэй ил тод, ойлгомжтой байх нь нөхцөлийг бүрдүүлсэн байх;

26.6.4.Иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагууд дундын мэдээллийн сангаар дамжуулан ашиглах боломжтой байх;

26.6.5.Хаягт суурилсан замчлах системийг олон нийтэд нээлттэй ил тод, ашиглах боломжийг бүрдүүлсэн байх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТӨЛӨВЛӨЛТ

27 дугаар зүйл. Газар зохион байгуулалт

27.1.Газар зохион байгуулалт нь хоорондоо уялдаатай, тасралтгүй хэрэгжих дараах цогцолбор арга хэмжээнээс бүрдэнэ:

27.1.1.газрыг зүй зохистой төлөвлөх;

27.1.2.газрыг үнэлэх, газрын татвар, төлбөр, нөхөн олговрын хэмжээг тогтоох;

27.1.3.газрыг бусдын өмчлөл, газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

27.1.4.кадастр эрхлэх, бүртгэл хөтлөх;

27.1.5.газрын төлөв байдал, чанарт хяналт тавих, мониторинг хийх;

27.1.6.цахим мэдээллийн нэгдсэн сан, систем эрхлэх;

27.1.7.газрыг хамгаалах, нөхөн сэргээх.

28 дугаар зүйл. Газар зохион байгуулалтын санхүүжилт

28.1.Газар зохион байгуулалтын ажлын норм, үнэлгээг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

28.2.Газар зохион байгуулалтын ажлыг дараах журмаар санхүүжүүлнэ:

28.2.1.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалт, хилийн цэс тогтоох, өөрчлөх, улсын газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөө боловсруулах, салбар хоорондын болон тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалт, төсөл, арга хэмжээ, газрын кадастр эрхлэх, газрын мониторинг, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа эрхлэх, төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх газар зохион байгуулалтын арга хэмжээ, улсын болон олон улсын чанартай төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой газар зохион байгуулалтын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс;

28.2.2.аймаг, нийслэл, сум, дүүрэг, хот, тосгон, бусад суурины газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс;

28.2.3.иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа газартаа хийлгэх газар зохион байгуулалтын үйл ажиллагааны зардлыг хариуцна;

28.2.4.иргэн, хуулийн этгээдийн гэм буруутай үйлдлийн улмаас газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээд нөхөн төлнө;

28.2.5.газар зохион байгуулалтын төлөвлөгөөг зөрчсөний улмаас учирсан хохирлыг арилгахтай холбоотой зардлыг гэм буруутай этгээд нөхөн төлнө.

29 дүгээр зүйл.Газар зохион байгуулалтын төлөвлөлт

29.1.Энэ хуулийн 27.2.1-д заасан арга хэмжээг газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр хэрэгжүүлнэ. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө дараах төрөлтэй байна:

29.1.1.улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;

29.1.2.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;

29.1.3.сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө;

29.1.4.улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөө;

29.1.5.улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө;

29.1.6.аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө;

29.1.7.сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь тайлбар бичиг, зураг, схем, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын тооцоо болон бусад холбогдох материалаас бүрдэнэ.

29.3.Энэ хуулийн 29.1-д заасан төлөвлөгөөг боловсруулах аргачлал, зааврыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

29.4.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг газрын асуудал эрхэлсэн Засгийн гишүүн батална.

29.5.Энэ хуулийн 29.1.2, 29.1.4-т заасан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөлд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргана.

29.6.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг дараах тохиолдолд тодотгоно:

29.6.1.үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд өөрчлөлт орсон, шинэчлэгдсэн;

29.6.2.газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн холбогдох байгууллага түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тодотгох, шинэчлэх дүгнэлт гаргасан.

29.7.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 28.1-т заасан бүх шатны газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөг энэ хуулийн 25.1-д заасан газрын удирдлагын цахим системд байршуулах ажлыг хариуцан зохион байгуулна.

29.8.Бүх шатны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

29.9.Энэ хуулийн 28.1.1-28.1.4-т заасан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хугацаа дуусгавар болохоос 6 сарын өмнө шинэчлэн батална.

30 дугаар зүйл.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тавигдах нийтлэг шаардлага

30.1.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахад Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтлах бөгөөд дараах нийтлэг шаардлагад нийцсэн байна:

30.1.1.хүний эрүүл, аюулгүй байдал, байгаль экологийн тэнцвэрт байдал, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх;

30.1.2.улс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдаж, түүний зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

30.1.3.салбар хоорондын уялдаа, иргэд, олон нийтийн оролцоог хангасан байх;

30.1.4.нэгдмэл, цогц, харилцан уялдсан байх;

30.1.5.газар, байгаль, нийгэм, эдийн засгийн нөхцөл, нөөцийн судалгаа шинжилгээ, үнэлгээнд үндэслэсэн байх;

30.1.6.газрын өмчийн хэлбэр, ашиглалтын зориулалтыг үл харгалзан газрын нэгдмэл сангийн бүх ангиллаар төлөвлөх;

30.1.7.газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний зураг төслийг боловсруулах журмыг мөрдөх;

30.1.8.газар зохион байгуулалтын төлөвлөгөөний зураг төсөл түүнтэй холбоотой бусад суурь судалгааны мэдээллийг геодезийн байрлал, тусгаг, өндрийн нэгдсэн тогтолцоонд тулгуурлан гаргах;

30.1.9.оновчтой төлөвлөлтийн хувилбаруудыг дэвшүүлж, түүний зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам, үе шат, түүнд шаардлагатай нөөцийг тогтоосон байх;

30.1.10.газар зохион байгуулалтын төлөвлөгөөг энэ хуулийн 25.1-д заасан системд бүртгүүлэх.

31 дүгээр зүйл.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

31.1.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газар, байгалийн нөхцөл, нөөц, түүний экологи, эдийн засаг, орон зайн багтаамж, чадавхад зохицсон, газрын менежментийн бодлогоор улс, орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 16-20 жилийн хугацаанд үе шаттай хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна.

31.2.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь аймаг, нийслэл, сумын болон тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний үндэс болох бөгөөд ерөнхийгөөс нарийвчлах зарчмаар нутаг дэвсгэрийн нэгжээр шатлан боловсруулж хэрэгжүүлнэ.

31.3.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө дараах агуулгатай байна:

31.3.1.уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх, нүүдлийн хэв маяг, соёлыг хадгалсан бүс нутгийн байршил, хэмжээ, хил зааг, холбогдох шийдэл, тооцоо;

31.3.2.эрчимжсэн суурин аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх, кластерын систем нэвтрүүлэх бүс нутаг, үндэсний хэмжээний агро-технологийн төрөлжсөн парк байгуулах байршил, хэмжээ, хил зааг, холбогдох шийдэл, тооцоо;

31.3.3.суурин мал аж ахуйг, бэлчээрийн мал аж ахуйтай хослон хөгжүүлэх бүс нутгийн байршил, хэмжээ, хил зааг;

31.3.4.жимс, жимсгэнийн аж ахуй хөгжүүлэх бүс нутгийн байршил, хэмжээ, холбогдох шийдэл, тооцоо;

31.3.5.улсын чанартай дамжин өнгөрөх бэлчээр, аймаг дундын отрын бэлчээр, улсын нөөцийн хадлангийн талбайн байршил, хэмжээ, хил зааг;

31.3.6.хот, тосгон, бусад суурины эдэлбэр газрын хил зааг, холбогдох шийдэл, тооцоо;

31.3.7.хот, тосгон, бусад суурины эдэлбэр газарт орших болон тэндээс нүүлгэн шилжүүлэх, шинээр байгуулах, хөнгөн, хүнд, уул уурхайн үйлдвэрийн цогцолбор өргөтгөн хөгжүүлэх газрын схемчилсэн байршил, хэмжээ, хил зааг;

31.3.8.шинээр баригдах улс хоорондын болон улс, бүс нутгийн ач холбогдолтой төмөр зам, авто зам, усан зам, нисэх буудлын газрын болон эрчим хүч дамжуулах, харилцаа холбооны сүлжээ, барилга байгууламж байгуулах газрын схемчилсэн байршил, хэмжээ, хил зааг;

31.3.9.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газар, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр ашиглуулах газрын байршил, хэмжээ, хил зааг;

31.3.10.ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос хайх, ашиглахыг хориглох, хязгаарлах бүс газрын хэмжээ, байршил, хил зааг;

31.3.11.газрын тос, уламжлалт бус газрын тос, байгалийн хий, ус дамжуулах хоолойн барилга байгууламж, тэдгээрийн зурвас газрын схемчилсэн байршил, хэмжээ, хил зааг;

31.3.12.ойн сан, усан сангийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, шинээр ойжуулах, ойн зурвас байгуулах бүс нутгийн схемчилсэн байршил, хэмжээ, хил зааг;

31.3.13.гол, мөрний урсац бүрэлдэх эх, түүний байршил, хэмжээ, хил зааг, түүний ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн арга хэмжээ;

31.3.14.улсын тусгай хэрэгцээнд авах газрын байршил, хэмжээ, хил зааг;

31.3.15.аялал жуулчлал, амралт, сувилал, агнуурын аж ахуйн газар нутгийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх зориулалтаар ашиглах, хамгаалах газрын хэмжээ, байршил, зориулалт, хил зааг, хэрэгжүүлэх арга хэмжээ, баримтлах газрын менежментийн хувилбар;

31.3.16.цөлжилтөөс сэргийлэх, сааруулах, тэмцэх арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүс нутгийн байршил, хэмжээ, хил зааг;

31.3.17.газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой боловсруулах эрх зүйн баримт бичгийн жагсаалт;

31.3.18.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг өөрчлөх, тодотгох хувилбар, шийдэл.

31.4.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага боловсруулж, Улсын Их Хурал батална.

31.5.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 5 жил тутамд боловсруулж, Засгийн газар батална.

31.6.Засгийн газар улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг Улсын Их Хуралд 5 жил тутам танилцуулна.

32 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

32.1.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь 8-12 жилийн хугацаанд үе шаттай хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөлт, зураг төслийн баримт бичиг байна.

32.2.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг энэ хуулийн 29.2-т заасан агуулгын хүрээнд аймаг, нийслэлийн хэмжээнд нарийвчлан төлөвлөх бөгөөд дараах зүйлийг тусгана:

32.2.1.газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилал хооронд шилжүүлэх газрын байршил, хэмжээ, хил зааг, уг ажлын хүрээнд хийгдэх газар зохион байгуулалтын ажлын төрөл, төсөвт өртгийн тооцоо;

32.2.2.аймаг, нийслэлийн ногоон бүс, зуслангийн бүсийн байршил, хэмжээ, хил зааг, холбогдох шийдэл, тооцоо;

32.2.3.шинээр баригдах аймаг, нийслэлийн чанартай төмөр зам, авто замын зурвас газар, эрчим хүч, цахилгаан, харилцаа холбооны шугам сүлжээ байгуулах газар, түүний хамгаалалтын зурвас газрын байршил, хэмжээ, хил зааг, холбогдох шийдэл, тооцоо;

32.2.4.ойн сан бүхий газар, ойн сангийн ашиглалт, хамгаалалтын бүсийн хил, зааг;

32.2.5.усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалт, эрүүл ахуйн бүсийн байршил, хэмжээ, хил зааг, холбогдох шийдэл, тооцоо;

32.2.6.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох болон олгохыг хориглох газрын байршил, хэмжээ, хил зааг;

32.2.7.сум, дүүргийн хилийн цэсэд өөрчлөлт оруулах, тодотгох саналын хувилбар.

32.3.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэл газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулж, тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

32.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

32.5.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг 4 жил тутам газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

32.6.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймаг нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад дунд болон богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 5 жил тутамд боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

33 дугаар зүйл.Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүний агуулга

33.1.Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь 5-7 жилийн хугацаанд үе шаттай хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөлт, зураг төслийн баримт бичиг байна.

33.2.Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг аймгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулах бөгөөд тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлснээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

33.3.Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүний арга хэмжээ нь улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл, арга хэмжээг тусгасан, сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд үе шаттайгаар шууд тусгаж хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан байна.

33.4.Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө дараах агуулгатай байна:

33.4.1.өвөл, хавар, зун, намарт хуваарилан ашиглах бэлчээрийн хил зааг, түүнийг сэлгэн ашиглах хуваарь;

33.4.2.бэлчээр ашиглалтын хэсэг, түүнийг ашиглах цаг хугацаа болон бэлчээрлүүлэх малын тоо, төрөл, сүргийн эргэлтийг төлөвлөх;

33.4.3.мал тууварлах, бэлчээх зорилгоор бусдын газрыг дамжин өнгөрөх бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил зааг;

33.4.4.нийтээр ашиглах, байгалийн тогтоцоор бий болсон гол, горхи, нуур, цөөрөм, хужир мараа, уст цэг бүхий бэлчээрийн байршил, хэмжээ, хил зааг;

33.4.5.хөдөө аж ахуйн барилга байгууламж байгуулах газрын байршил, хэмжээ, зориулалт;

33.4.6.цаа буга, зэрлэг амьтны бэлчээрийн газрын хил зааг;

33.4.7.отрын нөөц нутгийн байршил, хэмжээ, хил зааг, даац багтаамж;

33.4.8.сум, багийн тэжээлийн сангийн хадлангийн газар, хадах боломжтой бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил зааг, сэлгээтэй ашиглах хуваарь;

33.4.9.бэлчээрийн усан хангамжийг сайжруулах газрын байршил, хэмжээ, хил зааг;

33.4.10.сум, баг, бэлчээр ашиглагчдын хэмжээнд тооцсон сүргийн зохистой бүтэц, сүргийн эргэлт, малын гаралтай бүтээгдэхүүн борлуулалтын орлогын тооцоо;

33.4.11.газар тариалан, жимс, жимсгэнэ, хүлэмжийн аж ахуй эрхлэх газар, эрчимжсэн суурин болон хагас суурин мал аж ахуй эрхлэх, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн газрын байршил, хэмжээ, хил зааг;

33.4.12.хот, тосгон, бусад суурины газрын газар зохион байгуулалтын бүсчлэл, бүсчлэлд тавигдах шаардлага;

33.4.13.зам, шугам сүлжээ, бусад дэд бүтцийн сүлжээний газрын хэмжээ, байршил;

33.4.14.ойн сан бүхий газар, ойн сангийн ашиглалт, хамгаалалтын бүс хил зааг, ойн сангийн газрыг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, ойн зурвас байгуулах газрын байршил, хэмжээ, ойн нөхөрлөлд гэрээгээр ашиглуулах газрын байршил, хэрэгжүүлэх арга хэмжээ;

33.4.15.усны сан бүхий газар, ундны усны онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн хил зааг, усны сан бүхий газрыг ашиглах, хамгаалах, хэрэгжүүлэх арга хэмжээ;

33.4.16.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох газрын байршил, хэмжээ, хил зааг;

33.4.17.орон нутгийн тусгай хэрэгцээний газрыг өргөтгөх, шинээр авах, гаргах газрын хэмжээ, байршил, түүнийг ашиглах, хамгаалах, хэрэгжүүлэх арга хэмжээ;

33.4.18.амралт, рашаан сувилал, аялал жуулчлал, ан агнуурын бүс газар, маршрутын байршил, хэмжээ, байршил, түүнийг ашиглах, хамгаалах, хэрэгжүүлэх арга хэмжээ;

33.4.19. газрын мониторингийн үр дүнд үндэслэн боловсруулсан газрыг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээ, газрын хэмжээ, байршил.

33.5.Сумын Засаг дарга сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

34 дугаар зүйл.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө

34.1.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө нь улс, бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөлт, зураг төслийн баримт бичиг байна.

34.2.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна:

34.2.1.санхүүжилтийн баталгаат эх үүсвэртэй, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, байршил, хэмжээ, хил заагийг нарийвчлан тогтоосон зураг төсөлтэй байх;

34.2.2.улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан байх;

34.2.3.улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгагдсан байх;

34.3.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө дараах агуулгатай байна:

34.3.1.улсын төсвийн хөрөнгө оруулалт, концессын гэрээгээр хийгдэх инженер, нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж байгуулах газрын байршил, хэмжээ, хил зааг;

34.3.2.ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайн байршил, хэмжээ, хил зааг;

34.3.3.стратегийн ач холбогдол бүхий орд газрыг ашиглуулах газрын байршил, хэмжээ, хил зааг;

34.3.4.улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, өөрчлөлт оруулах газрын байршил, хэмжээ, хил зааг, зориулалт;

34.3.5.улсын тусгай хамгаалалттай газар нутагт гэрээгээр ашиглуулах газрын байршил, хэмжээ, хил зааг, зориулалт;

34.3.6.газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой, геодези, зураг зүйн ажил гүйцэтгэх газрын байршил, төсөвт өртгийн тооцоо;

34.3.7.Монгол Улсын иргэнд өмчлүүлэх газрын байршил, хэмжээ, хил зааг;

34.3.8.нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан чөлөөлөх газрын байршил, хэмжээ, хил зааг, нөхөх олговрын хэмжээ, холбогдох төсөвт өртгийн тооцоо;

34.3.9.газар, байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамжийн хэмжээ, түүнээс газар зохион байгуулалт, кадастрын ажил, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээнд зарцуулах төсөвт өртгийн тооцоо.

34.4.Салбар яам, агентлаг нь эрхлэх асуудлынхаа хүрээнд улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгах төсөл, арга хэмжээний саналаа жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

34.5.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага яам, агентлагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн төслийн эхний хувилбарыг боловсруулж, холбогдох аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас санал авахаар 8 дугаар сарын 1-ны дотор энэ хуулийн 25.2-т заасан газрын удирдлагын цахим системд байршуулна.

34.6.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга саналаа боловсруулан тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дүгнэлт гаргуулан 9 дүгээр сарын 15-ны дотор газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

34.7.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор боловсруулж, Засгийн газар 11 дүгээр сарын 20-ны дотор батална.

34.8.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэгтгэж дараа оны 3 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт тайлагнана.

35 дугаар зүйл. Улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөө

35.1.Улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь дунд хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөлт, зураг төслийн баримт бичиг байна.

35.2.Энэ хуулийн 19.1.1, 19.1.13-т заасан улсын тусгай хэрэгцээний газарт газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулна.

35.3.Тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөө дараах агуулгатай байна:

35.3.1.газар ашиглалтын зөвшөөрөгдөх, хориглох, хязгаарлах хэм хэмжээг тогтоосон газар ашиглалтын бүсчлэл, түүний дэглэм, горим;

35.3.2.тухайн газарт хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн тооцоо, хүлээгдэж буй үр ашгийн үзүүлэлт;

35.3.3.дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулах газрын байршил, хэмжээ;

35.3.4.газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ажлын төсөөлөл, төсөвт өртгийн тооцоо;

35.3.5.газрыг эргүүлэн авахтай холбоотой нөхөх олговрын хэмжээ, эсхүл солих газрын байршил, хэмжээ, үнэ;

35.3.6.газар, байгалийн нөөц ашигласны төлбөр, хураамжийн хэмжээ, түүнээс газар зохион байгуулалт, кадастрын ажил, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээнд зарцуулах төсөвт өртгийн тооцоо;

35.3.7.зам, шугам сүлжээ, бусад дэд бүтцийн барилга байгууламж байгуулах газрын байршил, хэмжээ;

35.3.8.шинээр хот, тосгон, суурин байгуулах газрын байршил, хэмжээ;

35.3.9.уул уурхайн үйлдвэрлэлд ашиглуулах газрын байршил, хэмжээ.

35.4.Улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж Засгийн газар батална.

36 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө

36.1.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө нь тухайн жилдээ хэрэгжүүлэх газар зохион байгуулалт, зураг төслийн баримт бичиг байна.

36.2.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө нь улс, аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүний үе шатны төслүүд, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө байна.

36.3.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.

36.4.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний нийт арга хэмжээг зураг төсөл, хээрийн хэмжилт, судалгаа хийж, байршил, хэмжээг нарийвчлан тогтоон нэгж талбар бүрээр төлөвлөсөн байна.

36.5.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө дараах агуулгатай байна:

36.5.1.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрын эрх олгох, гэрээ байгуулах газрын байршил, хэмжээ, зориулалт;

36.5.2.газар, байгалийн нөөц ашигласны төлбөр хураамжийн хэмжээ, түүнээс газар зохион байгуулалт, кадастрын ажил, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээнд зарцуулах төсөвт өртгийн тооцоо;

36.5.3.түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг гэрээгээр ашиглуулах газрын байршил, хэмжээ;

36.5.4.орон нутгийн тусгай хэрэгцээнд авах, гаргах газрын хэмжээ, байршил, нөхөн олговрын тооцоо;

36.5.5.газар чөлөөлөх газрын хэмжээ, байршил, түүнд шаардагдах төсөвт өртгийн тооцоо;

36.5.6.зам, шугам сүлжээ, бусад дэд бүтцийн барилга байгууламж байгуулах газрын байршил, хэмжээ, зориулалт;

36.5.7.шинээр хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл боловсруулах газрын байршил, хэмжээ төсөвт өртгийн тооцоо;

36.5.8.элэгдэл, эвдрэлээс хамгаалах, нөхөн сэргээх, тордон сайжруулах газрын байршил, хэмжээ, төсөвт өртгийн тооцоо;

36.5.9.аймгийн гэрээгээр ашиглуулах хадлангийн газрын ашиглах хугацаа байршил, хэмжээ;

36.5.10.сум дундын отрын нөөц нутгийн даац багтаамж, ашиглах улирал, оторлох хугацаа, ус хангамжийн байршил;

36.5.11.нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан чөлөөлөх газрын хэмжээ, байршил, нөхөн олговрын хэмжээ, төсөвт өртгийн тооцоо;

36.6.Дараах тохиолдолд аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрын эрх олгох арга хэмжээ төлөвлөхийг хориглоно:

36.6.1.хөдөө аж ахуйн газрын үндсэн ангилалд хамаарах бэлчээрийн газарт хот, тосгон, бусад суурины ангилалд хамаарах зориулалтаар, тариалангийн газрын ангилалд шилжүүлээгүй бэлчээрийн газарт тариалангийн ангилалд хамаарах зориулалтаар;

36.6.2.газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл, дүрэм болон хуулиар тогтоосон хориглолт, хязгаарлалтын бүс, зурвас газрын дэглэм, горимыг зөрчсөн байршилд;

36.6.3.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөөр инженер, нийгмийн дэд бүтэц төлөвлөгдөж, суурьшлын бүсчлэл тогтоогоогүй байршилд гэр бүлийн хэрэгцээнд гэр, орон сууцны хашааны зориулалтаар.

36.7.Сум, дүүргийн Засаг дарга аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгах саналын төслийг боловсруулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, жил бүрийн 11 дүгээр сарын 15-ний дотор аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

36.8.Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргаан байгууллага нэгтгэн боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 12 дугаар сарын 10-ны дотор батална.

36.9.Сумын газрын даамал, дүүргийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн газрын

асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 12 дугаар сарын 15-ны дотор тус тус тайлагнана.

37 дугаар зүйл. Сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө

37.1. Сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө нь сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд боловсруулсан газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тухайн жилд хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна.

37.2. Аймгийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.

37.3. Сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө дараах агуулгатай байна:

37.3.1. элэгдэл, эвдрэлээс хамгаалах, нөхөн сэргээх, тордон сайжруулах газрын байршил, хэмжээ, төсөвт өртгийн тооцоо;

37.3.2. бэлчээрийг улирлаар сэлгэн ашиглах хуваарь, хил зааг, байршил, хэмжээ;

37.3.3. бэлчээр ашиглалтын хэсэг, түүнийг ашиглах цаг хугацаа болон бэлчээрлүүлэх малын төрөл, тоо;

37.3.4. гэрээгээр ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалт;

37.3.5. малын тоог бэлчээрийн газрын экологийн чадавх, даацад тохируулах, бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил, зааг;

37.3.6. бэлчээрийн газрын төлөв байдал, чанар, сэргэх чадавхын мэдээлэлд үндэслэн ашиглалтаас чөлөөлөх, сэлгэх, нөхөн сэргээх, хамгаалах, хуваарь, байршил, хэмжээ, хил зааг;

37.3.7. хадлангийн газрыг зохистой ашиглах, сайжруулах байршил, өнжөөж амраах улирал, хугацаа;

37.3.8. хадлангийн талбайн зориулалтаар гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил зааг;

37.3.9. сумын отрын нөөц нутгийн даац багтаамж, ашиглах улирал, оторлох хугацаа, ус хангамжийн байршил.

38 дугаар зүйл. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавих

38.1. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 23.1 дэх хэсэгт заасан газар зохион байгуулалтын төлөвлөгөө хоорондын уялдааг хангаж, хэрэгжилтэд хяналт тавина.

38.2. Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөг улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй нийцүүлэх, хоорондын уялдааг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

38.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл нь

Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх талаар дүгнэлт гаргана.

38.4.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийн үр дүнгийн шинжилгээ хийлгэх асуудлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулж, Засгийн газарт тайлагнана.

38.5.Аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, гүйцэтгэлийн үр дүнгийн шинжилгээ хийлгэх асуудлыг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлагнана.

39 дүгээр зүйл. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний ил тод, нээлттэй байдлыг хангах

39.1.Аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төслийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цахим орчинд болон хэвлэмэл байдлаар нийтэд нээлттэй байршуулж 28-аас доошгүй хоногийн хугацаанд олон нийтийн саналыг авна.

39.2.Эрх бүхий байгууллагын баталсан бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний баримт бичгийг газрын мэдээллийн улсын нэгдсэн санд нээлттэй байршуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨРИЙН ӨМЧИЙН ГАЗРЫГ БУСДЫН ӨМЧЛӨЛД ШИЛЖҮҮЛЭХ

40 дүгээр зүйл.Газар өмчлөх эрх

40.1.Газар өмчлөх төрийн эрх нь газрын хөрс, түүний дээр салшгүй бэхлэгдсэн үл хөдлөх эд хөрөнгө, ургамал, газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, агаарын орон зайд хамаарна.

40.2.Төрийн өмчийн газрыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн /цаашид “иргэн” гэх/-д өмчлөх эрхээр шилжүүлж болно.

40.3.Монгол Улсын иргэний газар өмчлөх эрх нь газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, агаарын орон зайд хамаарахгүй.

40.4.Газар өмчлөгч иргэн өмчилсөн газрын зааг, эргэлтийн цэгийг өөрчлөхийг хориглоно.

40.5.Газар өмчлөгч иргэний эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр зохицуулж, хязгаарлана.

40.6.Иргэн өмчийнхөө газрыг зориулалтын дагуу бусдад шилжүүлэх харилцааг энэ хууль, Иргэний хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар зохицуулна.

41 дүгээр зүйл.Төрийн өмчийн газрыг иргэний өмчлөлд шилжүүлэхэд тавигдах нийтлэг шаардлага

41.1.Аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд заасан газарт газар олгоно.

41.2.Иргэний өмчлөх газар нь нийтийн эдэлбэр болон бусдын өмчлөлийн газартай давхцалгүй байна.

41.3.Дараах газрыг иргэний өмчлөлд шилжүүлэхийг хориглоно:

41.3.1.нийтийн эдэлбэрийн газар;

41.3.2.дэд бүтэц, зам, шугам сүлжээний хамгаалалтын газар;

41.3.3.түүх соёлын дурсгалт газар, соёлын өв бүхий газар;

41.3.4.ойн болон усны сан бүхий газар;

41.3.5.тусгай хэрэгцээний газар;

41.3.6.аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулах жилийн төлөвлөгөөнд иргэнд өмчлүүлэхээр зааснаас бусад газар.

42 дүгээр зүйл.Төрийн өмчийн газрыг иргэний өмчлөлд шилжүүлэх зориулалт

42.1.Төрийн өмчийн газрыг зөвхөн Монгол Улсын иргэний өмчлөлд хот, тосгон, бусад суурины эдэлбэр газрын ангилалд гэр бүлийн хэрэгцээнд нь гэр, амины орон сууц барих зориулалтаар шилжүүлж болно.

42.2.Иргэн өмчлөлийн газарт аж ахуйн зориулалтаар барилга байгууламж барих тохиолдолд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл, хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, хууль тогтоомжид заасны дагуу зөвшөөрөл авна.

43 дугаар зүйл.Төрийн өмчийн газрыг иргэний өмчлөлд шилжүүлэх журам

43.1.Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд иргэнд өмчлүүлж болохоор заасан газраас дараах журмаар иргэний өмчлөлд шилжүүлнэ:

43.1.1.иргэний өмчлөлд шилжүүлэхийг хориглосноос бусад, хуульд заасан хэмжээний газрыг иргэний өмчлөлд, түүний хүсэлтээр гэр бүлийн хэрэгцээнд нь гэр, амины орон сууц барих зориулалтаар нэг удаа, үнэгүй шилжүүлэх;

43.1.2.дуудлага худалдааны журмаар.

44 дүгээр зүйл.Газар өмчлөх эрх олгох

44.1.Иргэн газар өмчлөх хүсэлт гаргах, хүсэлтийг хянан шийдвэрлэх, дуудлага худалдааны журмаар газар өмчилж авах ажиллагаанд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд заасан журмыг баримтална.

44.2.Иргэний газар өмчлөх эрх нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

44.3.Иргэний газар өмчлөх эрхийн талаар Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мэдүүлнэ.

45 дүгээр зүйл. Монгол Улсын иргэний өмчлөлд шилжүүлэх газрын хэмжээ

45.1.Иргэний гэр бүлийн хэрэгцээнд нь гэр, амины орон сууц барих зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлэх газар байршлаасаа хамаарч дараах хэмжээтэй байна:

45.1.1.нийслэлд 0.07 хүртэл га;

45.1.2.аймгийн төвд 0.1 хүртэл га;

45.1.3.сумын төв, тосгонд 0.3 хүртэл га.

45.2.Дуудлага худалдааны журмаар олгох газрын хэмжээг улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд зааснаар тогтооно.

46 дугаар зүйл.Иргэн өмчийн газраа бусдад шилжүүлэх

46.1.Иргэн өмчийн газраа дараах төрлөөр иргэн, хуулийн этгээд шилжүүлж болно.

46.1.1.өмчлөх эрхээ Монгол улсын иргэнд гэрээний үндсэн дээр газар өмчлөх эрхээр;

46.1.2.өмчлөх эрхээ Монгол улсын иргэн, хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхээр.

47 дугаар зүйл.Иргэн өмчийн газраа ашиглуулах

47.1.Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл, хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд нийцүүлэн иргэн өөрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих зөвшөөрлийг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдэд олгож болно.

47.2.Иргэн энэ хуулийн 47.1-д заасан зөвшөөрлийг иргэн, хуулийн этгээдэд олгох, эсхүл өмчлөгч гэр, амины орон сууц барих зориулалтаас өөр зориулалтаар ашиглах бол дүүргийн газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гаргаж зориулалтыг өөрчлүүлнэ.

48 дугаар зүйл.Газар өмчлөх эрхийн зохицуулалт

48.1.Монгол Улсын иргэн газар өмчлөх хүсэлт гаргах, өмчлүүлэх шийдвэр гаргах, өмчлөх эрхийг дуусгавар болгох, иргэн газар өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх, газрын хязгаарлагдмал эрх олгох, газраа бусдад гэрээгээр ашиглуулахтай холбоотой харилцааг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Иргэний хуулиар зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ӨМЧИЙН ГАЗРЫГ БУСДАД ХЯЗГААРТАЙГААР ЭЗЭМШҮҮЛЖ, АШИГЛУУЛАХ

49 дүгээр зүйл. Газрын хязгаарлагдмал эрхийн төрөл

49.1.Төрийн өмчийн газрыг үр шимийг нь хүртэх, ашиг олох, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор дараах хязгаарлагдмал эрх /цаашид “газрын хязгаарлагдмал эрх” гэх/-ийн үндсэн дээр бусад этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно.

49.1.1.газрыг хязгаартайгаар эзэмших, ашиглах эрх /цаашид “газрын узуфрукт” гэх/;

49.1.2.төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх;

49.1.3.газрын хязгаарлагдмал болон газар өмчлөх эрхийг хязгаарлах эрх /цаашид “сервитут” гэх.

50 дугаар зүйл. Газрын хязгаарлагдмал эрх олж авах эрх бүхий этгээд

50.1.Газрын узуфруктыг зөвхөн Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн /цаашид “иргэн” гэх/, хуулийн этгээдэд олгоно.

50.2.Энэ хуулийн 50.1-д заасан хуулийн этгээдэд гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд хамаарахгүй.

50.3.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд олгоно.

50.4.Монгол улсын газрыг газрын хязгаарлагдмал эрхээр гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын хуулийн этгээд, олон улсын байгууллагад шилжүүлэхийг хориглоно.

51 дугаар зүйл. Газрын хязгаарлагдмал эрхээр олгох газрын хэмжээ

51.1.Төрийн өмчийн газарт газрын хязгаарлагдмал эрхээр олгох газрын байршил, хэмжээг улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд заасны дагуу тогтооно.

51.2.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх болон узуфрукт олгохыг хориглох газрын байршил, хэмжээг Засгийн газар тогтооно.

52 дугаар зүйл.Газрын хязгаарлагдмал эрхийн гэрээ

52.1.Газрын хязгаарлагдмал эрх олгох тухай шийдвэр, гэрчилгээг үндэслэн дүүргийн газрын алба, сумын газрын даамал эрх авсан иргэн, хуулийн этгээдтэй газрын хязгаарлагдмал эрхийн гэрээ байгуулна.

52.2.Газрын хязгаарлагдмал эрхийн гэрээнд дараах зүйлийг тусгана:

52.2.1.газрын хязгаарлагдмал эрхийн төрөл;

52.2.2.газрын хязгаарлагдмал эрх олгосон шийдвэрийн огноо, дугаар;

52.2.3.газрын зориулалт, хэмжээ;

52.2.4.газрын нэгж талбарын дугаар, хаяг;

52.2.5.газрын хязгаарлагдмал эрхийн хугацаа;

52.2.6.газрын төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа;

52.2.7.гэрээний талуудын эрх, үүрэг, хариуцлага;

52.2.8.газрыг хамгаалах, нөхөн сэргээх талаар хийх ажил;

52.2.9.гэрээг цуцлах үндэслэл;

52.2.10.бусад зүйл.

52.3.Газрын хязгаарлагдмал эрхийн гэрээний загвар, гэрээ дүгнэх журмыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

52.4.Газрын хязгаарлагдмал эрхийн гэрээ дүгнэх журамд заасан хугацаанд гэрээг дүгнэж, журмын хэрэгжилтийг хангах ажлыг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

53 дугаар зүйл.Газрыг хязгаарлагдмал эрхийн үндсэн дээр ашигласны төлбөр

53.1.Газрыг хязгаарлагдмал эрхээр ашигласны төлбөрийн хэмжээг Газрын төлбөрийн тухай хуульд заасны дагуу тогтооно.

53.2.Газрын төлбөрийн үүргийг газрын эрхийн бүртгэлд бүртгэнэ.

54 дүгээр зүйл.Газрын хязгаарлагдмал эрхийг барьцаалах, түрээслэх эрх

54.1.Газрын узуфруктыг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн Монгол Улсын иргэн, Монгол улсын хуулийн этгээдэд барьцаалж, түрээслэж болно.

54.2.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр иргэн, хуулийн этгээдэд барьцаалж, түрээслэж болно.

54.3.Газрын узуфрукт болон төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх барьцаалах хүсэлтийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд хууль ёсны ашиг сонирхол ноцтойгоор зөрчигдөхөөс бусад тохиолдолд зөвшөөрөл өгөхөөс татгалзах эрхгүй бөгөөд барьцаалах эрхийг бүртгэж, зөвшөөрөл олгоно.

54.4.Газрын узуфрукт болон бусдын газар дээр барилга байгууламж барих эрх барьцаалахад Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг баримтална.

54.5.Сервитутыг барьцаалах, түрээслэхийг хориглоно.

55 дугаар зүйл. Газрын узуфрукт болон төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх олгох

55.1.Газрын узуфрукт болон төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг дараах хэлбэрээр олгоно:

55.1.1.иргэний гаргасан хүсэлтэд үндэслэн нэг удаа үнэгүй;

55.1.2. дуудлага худалдаагаар;

55.1.3.төсөл сонгон шалгаруулалтаар.

55.2.Энэ хуулийн 56 дугаар зүйлд заасан үнэгүй олгох газрын хэмжээнээс илүү гарсан газрын хязгаарлагдмал эрхийг газрын суурь үнээр тооцон олгож болно. Газрын суурь үнэ тооцох аргачиллыг Засгийн газар батална.

56 дугаар зүйл.Газрын узуфрукт болон төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг үнэгүй олгох үндэслэл

56.1.Газрын узуфруктыг зөвхөн Монгол улсын иргэнд дараах зориулалтаар нэг удаа, үнэгүй олгож болно:

56.1.1.хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0,1 га-гаас илүүгүй газрыг.

56.2.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг Монгол Улсын иргэнд дараах зориулалтаар нэг удаа, үнэгүй олгож болно:

56.2.1.гэр бүлийн хэрэгцээнд нь амины орон сууц барих зориулалтаар 0.07 га-аас илүүгүй газрыг;

56.2.2.өвөлжөө, хаваржааны зориулалтаар 0,5 га-аас илүүгүй газрыг.

57 дугаар зүйл.Газрын узуфрукт болон төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг үнэгүй авах тухай хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх

57.1.Монгол Улсын иргэн газрын узуфрукт болон төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг үнэгүй авах хүсэлтээ дүүргийн газрын алба, сумын газрын даамалд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан журмын дагуу гаргана.

57.2.Дүүргийн газрын алба, сумын даамал хүсэлтийг хүлээн авч, бүртгэн, суурин болон хээрийн судалгааг хийж, аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад цахим системээр ажлын 5 өдрийн дотор шилжүүлнэ.

57.3.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага харьяаллын дагуу хүсэлтийг хянан үзэж, газрын хязгаарлагдмал эрх олгох, эсэх шийдвэрийг ажлын 15 хоногийн дотор гаргаж, хэрэв газар олгох бол газрын хязгаарлагдмал эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх мэдүүлгийг цахимаар Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд мэдүүлнэ.

57.4.Газрын хязгаарлагдмал эрх олгох тухай аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрт хязгаарлагдмал эрхийн төрөл, газрын байршил, хил зааг, зориулалтыг тусгана.

57.5.Харьяа улсын бүртгэлийн байгууллага дундын мэдээллийн санд мэдүүлсэн мэдүүлгийг хянаж бүртгэн, улсын бүртгэлийн дугаарыг дундын мэдээллийн санд ажлын 3 хоногийн дотор илгээх бөгөөд дүүргийн газрын алба, сумын газрын даамал улсын бүртгэлийн дугаарыг газрын хязгаарлагдмал эрхийн гэрчилгээнд тэмдэглэж цахим системээс хэвлэж, хувийн хэрэг нээн, кадастрын бүртгэлд бүртгэж, эрхийн гэрээ байгуулж, газрын хэмжээ, заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, координатжуулах, тэдгээрийн кадастрын зураг болон газрын төлөв байдал чанарын хянан баталгааны дүгнэлтийн хамт хүлээлгэн өгнө.

57.6.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд оруулсан мэдүүлэг, бусад баримт бичгийн үнэн зөвийг хариуцна.

57.7. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 57.5-д заасан улсын бүртгэлийн дугаар олголтын явцад байнгын хяналт тавьж ажиллана.

57.8.Иргэнд газрын хязгаарлагдмал эрх олгох, өргөдөл, гомдол, хүсэлт шийдвэрлэлтийн ил тод, нээлттэй байдлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цахим систем болон бусад хэлбэрээр хангаж ажиллана.

58 дугаар зүйл. Газрын узуфрукт болон төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын журмаар олгох

58.1.Энэ хуулийн 56 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд газрын узуфрукт болон төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын журмаар олгоно.

58.2.Төрийн өмчийн газар дээр хязгаарлагдмал эрх олгох дуудлага худалдааг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон энэ хуулийн 89.1-д заасан байгууллагын газрын бирж зохион байгуулна.

58.3.Газрын бирж газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын ялагчид эрхээ баталгаажуулах зөвшөөрлийг цахим системээр олгоно.

58.4.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газрын биржээс зөвшөөрөл олгосон иргэн, хуулийн этгээдэд газрын хязгаарлагдмал эрх олгох шийдвэр гаргаж, газрын хязгаарлагдмал эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх мэдүүлгийг цахимаар Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд мэдүүлнэ.

58.5.Газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын ялагчид газрын хязгаарлагдмал эрхийн гэрчилгээ олгох, гэрээ байгуулах, газрыг хүлээлгэн өгөхөд энэ хуулийн 57.5-58.8-д заасан журмыг баримтална.

59 дугаар зүйл.Газрын узуфруктын зориулалт

59.1.Газрын узуфруктыг дараах зориулалтаар олгоно:

59.1.1.төмс, хүнсний ногоо тарих;

59.1.2.самар, жимс, жимсгэнэ тарих;

59.1.3.таримал ургамал тарих;

59.1.4.цэцэг, эмийн ургамал тарих;

59.1.5.техник, тэжээлийн тосны ургамал тарих;

59.1.6.үр тариа тарих;

59.1.7.мод үржүүлэх;

59.1.8.хадлан хадах;

59.1.9.эрчимжсэн мал аж ахуй эрхлэх;

59.1.10.ан амьтан, тэжээвэр амьтны аж ахуй эрхлэх;

59.1.11.газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх;

59.1.12.хүлэмжийн аж ахуй эрхлэх;

59.1.13.хөдөө аж ахуйн хүнсний бүтээгдэхүүн хадгалах агуулах, зоорийн аж ахуй эрхлэх;

59.1.14.хөдөө ах ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор барих /эрдэм шинжилгээний сорилт, туршилтын газраас бусад/.

59.2.Иргэн, хуулийн этгээд, тэдгээрийн хамаарал бүхий этгээд нь нийтдээ 20 000 /хорин мянга/га-с илүү газарт узуфруктын газар эзэмшихийг хориглоно.

59.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тэдгээрийн хамаарал бүхий этгээд нь энэ хуулийн 59.2-т зааснаас илүү хэмжээтэй газрын узуфрукт эрх эзэмшиж байгаа нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү гарсан газрын узуфруктыг цуцалж, газрыг хураан авна.

60 дугаар зүйл.Газрын узуфруктын хугацаа

60.1.Газрын узуфруктыг 33 жилийн хугацаагаар олгоно. Газрын узуфрукт эзэмшигч нь гэрээний хугацаанд зориулалтын дагуу тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гэрээг нэг удаад 33 жилээр сунгаж болно.

60.2.Газрын узуфруктын хугацааг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс тоолно.

61 дүгээр зүйл.Газрын узуфрукт эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

61.1.Газрын узуфрукт эзэмшигч дараах эрх эдэлнэ:

61.1.1.газраа бусдад түрээслэх, барьцаалах;

61.1.2.газрын узуфруктын хугацааг сунгуулах хүсэлт гаргах;

61.1.3.газрын зориулалтыг өөрчлөхгүйгээр уг газрыг ашиглахад зайлшгүй шаардлагатай барилга байгууламж барих, тоног төхөөрөмж суурилуулах;

61.1.4.газрыг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээ, нийгмийн зайлшгүй хэрэгцээнд авах шийдвэр гарсан бол хуульд заасан нөхөн олговор авах;

61.1.5.газрын узуфруктын газарт учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх.

61.2.Газрын узуфрукт эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

61.2.1.газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагын шийдвэр, хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

61.2.2.газрын төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх;

61.2.3.газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг тогтоосон хугацаанд хийлгэх;

61.2.4.газрын төлөв байдал, чанарыг дордуулсан бол учруулсан хохирлыг тогтоосон журмын дагуу нөхөн төлөх;

61.2.5.газрын узуфруктыг барьцаалах, бусдад ашиглуулах тохиолдолд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авах;

61.2.6.барьцааны болон түрээсийн гэрээг газрын эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх;

61.2.7.бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;

61.2.8.газрыг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээ, нийгмийн

зайлшгүй хэрэгцээнд авах шийдвэр гарч, гэрээ байгуулсан бол хуульд заасан хугацаанд газрыг чөлөөлөх;

61.2.9.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

61.3.Газрын узуфрукт эзэмшигч узуфруктын зориулалтыг өөрчлөх, газрын хязгаарлагдмэл эрхийг гадаадын иргэн, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, олон улсын байгууллагад шилжүүлэх, ашиглуулахыг хориглоно.

62 дугаар зүйл.Газрын узуфруктыг бусдад шилжүүлэх

62.1.Газрын узуфруктыг бусдад шилжүүлэхгүй.

62.2.Газрын узуфрукт эзэмшигч нас барсан тохиолдолд түүний хууль ёсны өв залгамжлагч нь узуфруктын үлдсэн хугацаагаар үргэлжлүүлэн эрх залгамжилж болно. Энэ тохиолдолд өв залгамжлагч нь энэ зүйлд заасан журмын дагуу хүсэлтээ аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

62.3.Энэ хуулийн 62.2-д заасны дагуу шилжүүлж буй газрын узуфруктыг үлдсэн хугацаагаар олгоно.

63 дугаар зүйл.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх олгох зориулалт

63.1.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг иргэн, хуулийн этгээдэд дараах зориулалтаар олгоно:

63.1.1.амины орон сууц барих;

63.1.2.албан байгууллагын болон худалдаа, үйлчилгээний барилга барих;

63.1.3.үйлдвэр, үйлчилгээний барилга барих;

63.1.4.амралт, аялал жуулчлалын барилга байгууламж, цогцолбор барих;

63.1.5.зам, шугам сүлжээ барих;

63.1.6.цахилгаан, эрчим хүчний байгууламж, цамхаг барих;

63.1.7.ус хангамж, ариутгах татуургын байгууламж барих;

63.1.8.дулаан, хий дамжуулах, хөргөх барилга байгууламж барих;

63.1.9.харилцаа, холбооны барилга байгууламж, цамхаг барих;

63.1.10.нүхэн гарц, газар доор байгууламж барих;

63.1.11.гүүр, дүүжин гүүр барих;

63.1.12.нийтийн зориулалттай орон сууц барих.

63.1.13. уул уурхай эрхлэх;

63.1.14. ашигт малтмал, газрын тос, байгалийн хий ашиглах;

63.1.15.усан тээврийн зорилгоор орчны газрыг ашиглах;

63.1.16.биеийн тамир, спортын зорилгоор спорт цогцолборын дэвсгэр газар, орчны талбайг ашиглах.

63.2.Нийтийн зориулалттай орон сууцны барилгыг байнгын ашиглалтад шилжүүлсэн бол төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх

дуусгавар болж, түүний дэвсгэр болон орчны газрын эрхийг кондоминиум эрхээр сууц өмчлөгчдөд шилжүүлнэ.

63.3.Албан байгууллагын болон худалдаа, үйлчилгээний зориулалттай барилгын өрөө болон бусад талбайг олон этгээд өмчилж буй тохиолдолд тухайн барилгын дэвсгэр болон орчны газрын эрхийг энэ хуулийн 63.2-т заасны дагуу кондоминиум эрхээр өмчлөгчдөд шилжүүлнэ.

63.4.Кондоминиум эрхтэй холбоотой харилцааг Иргэний хууль, Орон сууцны тухай хуулиар зохицуулна.

64 дүгээр зүйл.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийн хугацаа

64.1.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг 33 жилийн хугацаагаар олгоно.

64.2.Энэ хуулийн 68.1-д заасан хугацааг нэг удаад сунгах хугацаа 33 жил байх бөгөөд нийт хугацаа Иргэний хуулийн 150.3-д заасан хугацаанаас хэтрэхгүй.

64.3.Иргэн, хуулийн этгээдэд төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийн хугацааг тогтоохдоо зориулалт, зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг баримтална.

64.4.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийн хугацааг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн тоолно.

64.5.Шилжүүлж буй төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийн хугацааг тухайн эрхийн үлдсэн хугацаагаар тооцно.

65 дугаар зүйл.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг шилжүүлэх

65.1.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх эзэмшигч нь бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр эрхээ бусдад шилжүүлж болно.

65.2.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх шилжүүлэх хүсэлтийг талууд хамтран дараах баримт бичгийн хамт тухайн дүүргийн газрын алба, сумын даамалд гаргана.

65.2.1.төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх нотариатаар баталгаажуулсан шилжүүлэх гэрээ;

65.2.2.барилга байгууламж барих эрх шилжүүлэн авч байгаа этгээд нь уг эрхийг шилжүүлэн авснаар үүсэх эрх, үүргийг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа тухай бичгээр гаргасан мэдэгдэл;

65.2.3.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

65.2.4.газрын эрхийн гэрчилгээ, гэрээ, газрын кадастрын зураг;

65.2.5.газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт.

65.3. Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх шилжүүлэх, гэрчилгээ олгох, гэрээ байгуулах, газрыг хүлээлгэн өгөхөд энэ хуулийн 57.2-57.8-д заасан журмыг баримтална.

65.4.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг өвлүүлэхэд Иргэний хуульд заасан журмыг баримтална. Өв залгамжлагч эрх шилжүүлэн авах хүсэлтээ тухайн дүүргийн газрын алба, сумын даамалд гаргана.

66 дугаар зүйл.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх эзэмшигчийн эрх, үүрэг

66.1.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

66.1.1.эрхийн хугацааг сунгуулах хүсэлт гаргах;

66.1.2.газрын эрхээ бусдад шилжүүлэх, өвлүүлэх, түрээслэх, барьцаалах;

66.1.3.барилга байгууламж барих;

66.1.4.газрыг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээ, нийгмийн зайлшгүй хэрэгцээнд авах шийдвэр гарсан бол хуульд заасан нөхөн олговор авах;

66.1.5.эрх олгогдсон газарт учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх.

66.2.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх эзэмшигч нь дараах үүрэг хүлээнэ:

66.2.1.газрын эрх олгох шийдвэр гарснаас хойш 14 хоногт багтаан газрын эрхийн гэрээ байгуулах;

66.2.2.газрыг зориулалтын дагуу ашиглах;

66.2.3.гэрээнд заасан үүргээ биелүүлэх;

66.2.4.газрын хэмжээ, байршилыг өөрчлөхгүй байх;

66.2.5.газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

66.2.6.газрын төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх;

66.2.7.газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэх;

66.2.8.бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;

66.2.9.газрыг улс, орон нутгийн тусгай хэрэгцээ, нийгмийн зайлшгүй хэрэгцээнд авах шийдвэр гарч, гэрээ байгуулсан бол хуульд заасан хугацаанд чөлөөлөх;

66.2.10.барьцааны болон түрээсийн гэрээг газрын эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх;

66.2.11.газрын төлөв байдал, чанарыг доройтуулсан бол учруулсан хохирлыг тогтоосон журмын дагуу нөхөн төлөх;

66.2.12.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

66.3.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг гадаадын иргэн, олон улсын байгууллагад шилжүүлэх, ашиглуулахыг хориглоно.

67 дугаар зүйл. Сервитут тогтоох

67.1.Сервитут нь дараах төрөлтэй байна:

67.1.1.нийтийн;

67.1.2.хувийн.

67.2.Нийтийн сервитутыг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн бусад этгээдийн газарт дор дурдсан зөвшөөрөгдсөн ашиглалтын төрлөөр тогтоож болно:

67.2.1.дамжин өнгөрөх;

67.2.2.хил заагийн болон геодезийн байнгын цэг, тэмдэгт тавих;

67.2.3.намагжилт, цөлжилтийг багасгах ажил гүйцэтгэх;

67.2.4.ус зайлуулах далан байгуулах;

67.2.5.инженерийн шугам, сүлжээ байгуулах, ашиглах;

67.2.6.хайгуул судалгаа, ижил төстэй бусад үйл ажиллагаа явуулах;

67.2.7.мод үржүүлгийн газар, байгаль хамгаалах бусад объектыг байгуулах;

67.2.8.ойн сангийн газарт ойн мод болон байгалийн дагалт баялаг ашиглах, аялах;

67.2.9.газар зохион байгуулалтын бусад арга хэмжээ хэрэгжүүлэх.

67.3.Тухайн нутаг дэвсгэрт сервитут тогтоох асуудлыг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хоёр ба түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан сервитут тогтоох асуудлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

67.4.Энэ хуулийн 67.3-д зааснаас бусад тохиолдолд нийтийн сервитут тогтоох шийдвэрийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргаж, сервитутаар эрх нь хязгаарлагдаж буй газар өмчлөгч, газрын хязгаарлагдмал эрхтэй этгээдэд мэдэгдэнэ.

67.5.Гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох зорилгоор бусдын газарт уг нөхцөл байдал арилтал нийтийн сервитутыг Засгийн газар тогтоох шийдвэр гаргаж болно.

67.6.Сервитут тогтоолгосон этгээд газрын эрх болон гэрээгээр газар ашиглах эрхтэй этгээдийн аливаа үйл ажиллагаанд саад учруулахыг хориглоно.

67.7.Хүн амын нийтийн ашиг сонирхлыг хангах зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд нийтийн сервитут тогтоохыг хориглоно.

67.8.Нийтийн болон хувийн сервитут тогтоох болон дуусгавар болгох шийдвэрийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэнэ.

67.9.Газар өмчлөгч, хязгаарлагдмал эрх эзэмшигч эрхээ хэрэгжүүлэх зорилгоор бусад газар өмчлөгч болон хязгаарлагдмал эрхийг хязгаарлах тохиолдолд талууд тохиролцон бичгээр гэрээ байгуулж, хувийн сервитут тогтоолгох хүсэлтээ аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

67.10.Энэ хуулийн 67.9-д заасан хүсэлтийг судлаж хувийн сервитутыг бүртгэж, газрын эрхийн мэдээллийн санд бүртгэнэ.

67.11.Сервитут тогтоосон газрын заагийг кадастрын зураг, схемийг энэ зүйлийн 67.9-д заасан гэрээнд хавсаргана.

67.12.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага барилгын ажил гүйцэтгэх явцад зайлшгүй шаардлагатай бол барилга барьж буй газрын зэргэлдээ орших газарт түр сервитут тогтоож болно.

67.13.Хувийн сервитут тогтоохтой холбоотой харилцааг Иргэний хуулиар зохицуулна.

68 дугаар зүйл. Сервитутын хугацаа

68.1.Сервитут нь байнгын болон түр хугацаатай байж болно.

68.2.Гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох зорилгоор тухайн нөхцөл, байдал арилтал түр сервитут тогтооно.

68.3.Газрын хязгаарлагдмал эрх бүхий этгээдийн газарт сервитут тогтоосон бол тухайн хязгаарлагдмал эрхийн хугацаагаар сервитутын гэрээ байгуулна.

69 дүгээр зүйл.Сервитутээр эрх нь хязгаарлагдсан этгээдийн эрх

69.1.Сервитутээр эрх нь хязгаарлагдсан этгээд дараах эрх эдэлнэ:

69.1.2.Өмчийн газар болон хязгаарлагдмал эрхтэй газарт нь нийтийн сервитут тогтоосноос газраа ашиглах боломжгүй буюу ашиглахад хүндрэл бэрхшээлтэй болох тохиолдолд уг газрыг худалдан авах, мөн түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх болон уг хүндрэл бэрхшээлтэй дүйцэхүйц хэмжээний төлбөр төлөхийг нийтийн сервитут тогтоосон эрх бүхий этгээдээс шаардах;

69.1.3.өмчийн газарт нь нийтийн сервитут тогтоосноос болж эрх, хууль ёсны ашиг сонирхол нь энэ хуулийн 70.1.4-т зааснаар хөндөгдсөн этгээд шүүхээр эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах.

70 дугаар зүйл.Газрын хязгаарлагдмал эрх дуусгавар болох

70.1.Дараах нөхцөлд газрын хязгаарлагдмал эрх дуусгавар болно:

70.1.1.газрын хязгаарлагдмал эрхийн хугацаа дууссан;

70.1.2.газрын хязгаарлагдмал эрх эзэмшигч эрхээсээ татгалзах, дуусгавар болгох хүсэлт гаргасан;

70.1.3.газрын хязгаарлагдмал эрхээ бусдад шилжүүлсэн;

70.1.4.хязгаарлагдмал эрхийг цуцалсан, хүчингүй болгосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

70.1.5.газрын хязгаарлагдмал эрхтэй иргэн нас барсан, нас барсан гэж зарлагдсан, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон бөгөөд түүний өв залгамжлагч байхгүй нь тогтоогдсон;

70.1.6.газрын хязгаарлагдмал эрхтэй хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан;

70.1.7.тусгай хэрэгцээнд авахаар тохиролцож нөхөн олговор олгосон, эсхүл өөр газраар солихоор тохиролцож гэрээ байгуулсан;

70.1.8.энэ хуульд заасан үндэслэлээр газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгох шийдвэр гарсан;

70.1.9.сервитутээр эрх нь хязгаарлагдсан иргэн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан;

70.1.10.газрын узуфрукт эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан,

дампуурсан.

70.2.Газрын хязгаарлагдмал эрхийг дуусгавар болгосон тухай шийдвэрийг тухайн газарт эрх олгосон аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргаж, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд тухай бүр бүртгүүлнэ.

70.3.Төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийн үндсэн дээр баригдсан барилга байгууламж нь тухайн эрхийн гол бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд барилга байгууламж нурсан, эвдэрсэн нь уг эрх дуусгавар болох үндэслэл болохгүй.

71 дүгээр зүйл. Газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгох

71.1.Газрын узуфрукт болон төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрх олгосон, нийтийн сервитут тогтоосон эрх бүхий байгууллага дараах тохиолдолд газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгоно:

71.1.1.газрыг арчлан хамгаалах, нөхөн сэргээх үүргээ ноцтой зөрчиж газрыг бохирдуулсан, газрын хэвийн байдлыг хадгалах үүргээ зөрчиж газрыг илтэд доройтуулсан;

71.1.2.газрын хязгаарлагдмал эрхийн газрыг зориулалтын дагуу 4 жил дараалан ашиглаагүй;

71.1.3.газрын төлбөрийг 2 жилийн хугацаанд төлөөгүй;

71.1.4.хууль тогтоомж зөрчиж газрыг гадаадын иргэн, гадаадын хуулийн этгээд, олон улсын байгууллагад шилжүүлж, ашиглуулсан нь тогтоогдсон;

71.1.5.газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласныг хяналт шалгалтын байгууллага дүгнэлтээр тогтоосон;

71.1.6.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр газрын узуфруктыг бусдад шилжүүлсэн.

71.2.Энэ хуулийн 70.1.1, 70.1.4, 70.1.5, 70.1.6-т заасан зөрчил гарсан бол газрын хязгаарлагдмал эрхийг нэн даруй хүчингүй болгох үндэслэл болно.

71.3.Энэ хуулийн 70.1.2, 70.1.3-т заасан үндэслэлээр газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгох шийдвэр гаргахаас 3 сарын өмнө эрх эзэмшигчид нь хуульд заасан хэлбэрээр мэдэгдэж, сануулна.

71.4.Газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгох шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтан Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу сонсгох ажиллагаа хийж, хүчингүй болгосон шийдвэрээ дундын мэдээллийн цахим санд бүртгэнэ.

71.5. Энэ хуулийн 70.1-д заасан үндэслэлээр газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгосон бол газар чөлөөлөхтэй холбоотой зардал, газарт учирсан хохирлыг уг эрхийг эзэмшиж байсан этгээдээр нөхөн төлүүлнэ.

71.4.Барьцаанд байгаа газрын хязгаарлагдмал эрхийг хүчингүй болгосон тохиолдолд эрх эзэмшигчийн барьцааны гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг нь төрд шилжинэ.

71.5.Газрын хязгаарлагдмал эрхийг энэ хуулийн 70.1.3-т заасан үндэслэлээр хүчингүй болгох шийдвэр гарсны дараа газрын төлбөрөө төлсөн нь эрхийг сэргээх үндэслэл болохгүй.

71.6.Газрын хязгаарлагдмал эрхийг дуусгавар болгох, хүчингүй болгох тухай шийдвэрийн талаар эрх эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад болон барьцаалагч шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гартал тухайн газрыг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

72 дугаар зүйл. Газрын узуфрукт болон төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийн хугацаа дуусахаас өмнө газрыг өөр газраар солих, эсхүл эргүүлэн авах

72.1.Газрын узуфрукт болон төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийн хугацаа дуусахаас өмнө нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн дагуу газрыг өөр газраар солих, эсхүл газрыг эргүүлэн авч болно.

73 дугаар зүйл.Газрын хязгаарлагдмал эрх дуусгавар болоход газар чөлөөлөх

73.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газрын хязгаарлагдмал эрх дуусгавар болоход хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол уг газрыг 45 хоногийн хугацаанд чөлөөлж, дүүргийн газрын алба, сумын даамалд хүлээлгэн өгнө.

73.2.Газрын хязгаарлагдмал эрхийн хугацаа дуусгавар болоход уг газарт салшгүй бэхлэгдсэн ердийн ашиглалтад байгаа барилга байгууламжийн үнийг газар өмчлөгч буюу төр төлөх үүрэгтэй.

73.3.Энэ хуулийн 66.1.4-д заасан үндэслэлээр газар чөлөөлөхтэй холбогдон гарах зардлыг холбогдох хуулиар зохицуулна.

73.4.Энэ хуулийн 73.1-д заасан хугацаанд газраа чөлөөлөөгүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу албадан нүүлгэнэ.

73.5.Энэ хуулийн 73.1-д заасан үндэслэлээр газар чөлөөлөхтэй холбогдон гарах зардлыг газрын хязгаарлагдмал эрхийг эзэмшиж байсан этгээд хариуцна. Энэ тохиолдолд уг газарт салшгүй бэхлэгдсэн барилга байгууламжийн үнийг төр хариуцахгүй.

73.6.Газрын хязгаарлагдмал эрхийн хугацаа дуусах үед уг эрх нь барьцаанд байгаа бол барьцаалагч нь барьцаагаар хангагдах үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй.

73.7.Барилга байгууламж барих зориулалтаар газар эзэмших эрх дуусгавар болоход газар өмчлөгч нь барилга байгууламж барих эрхийг эзэмшиж байсан этгээдийн гуравдагч этгээдтэй байгуулсан хөлслөх, түрээслэх гэрээний оролцогч болно.

73.8.Газрын хязгаарлагдмал эрхээр олгогдсон газар нь байгалийн давагдашгүй хүчин зүйл, гамшиг, аюулт үзэгдэлд өртөгдөж цаашид тухайн зориулалтаар ашиглах боломжгүй болсон тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн эрх эзэмшигчийн хүсэлтээр уг газрыг засаж тохижуулах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН ӨМЧИЙН ГАЗРЫГ БУСДАД АШИГЛУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТ

74 дүгээр зүйл.Төрийн өмчийн газрыг бусдад ашиглуулах

74.1.Төрийн өмчийн газрыг энэ хуульд заасан зориулалт, үндэслэл, зөвшөөрөл, журмын дагуу дараах этгээдэд гэрээгээр ашиглуулж болно.

74.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

74.1.2.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд;

74.1.3.гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хуулийн этгээд;

74.1.4.гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, консулын газар, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газар.

75 дугаар зүйл.Газар ашиглах гэрээ

75.1.Газар ашиглах гэрээгээр нэг тал нь нөгөө талдаа газрыг төлбөртэй болон хариу төлбөргүйгээр ашиглуулахаар шилжүүлэх, нөгөө тал нь газрыг хуульд заасан зориулалтын дагуу ашиглаж, гэрээ дуусгавар болоход хэвийн байдалтай буцааж өгөх үүргийг тус тус хүлээнэ.

75.2.Хуульд өөрөөр заагаагүй бол газар ашиглах гэрээг бичгээр байгуулах бөгөөд газрын эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

75.3.Газар ашиглах гэрээнд газар ашиглах шийдвэрийн дугаар, огноо, гэрээний хугацаа, сунгах журам, газар ашиглах зориулалт, ашиглах газрын хэмжээ, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, газар ашигласны төлбөр болон газрыг хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээг тусгана.

75.4.Энэ хуулийн 80.1, 80.2-т заасан шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

75.5.Газар ашиглах гэрээний загварыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

76 дугаар зүйл.Газар ашиглуулах гэрээний хугацаа

76.1.Газар ашиглуулах гэрээ нь хугацаатай буюу хугацаагүй байж болно.

76.2.Газар ашиглуулах хугацаатай гэрээний хугацааг газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө, газар ашиглах зориулалт, ашиглагч этгээдийн хүсэлт, эрх бүхий байгууллагын зөвшөөрлийн хугацааг харгалзан энэ хуульд заасан журмын дагуу тогтооно.

76.3.Газар ашиглагч газар ашиглах гэрээний хугацааг сунгах тухай хүсэлтээ гэрээний үндсэн хугацаа дуусгавар болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө газар ашиглах зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

76.4.Газар ашиглагч газар ашиглах гэрээний хугацааг эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр сунгаж болно.

77 дугаар зүйл.Төрийн өмчийн газрыг бусдад ашиглуулах шийдвэр гаргах, гэрээ байгуулах

77.1.Дараах эрх бүхий байгууллага, албан тушаалтан дор дурдсан үндэслэлээр газар ашиглуулах шийдвэр гаргана:

77.1.1.Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах шийдвэрийг улсын болон аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн

төлөвлөгөө, газар ашиглах хүсэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

77.1.2.гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, консулын газар, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газарт газар ашиглуулах шийдвэрийг улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн Засгийн газар;

77.1.3.гадаадын иргэн, харьяалалгүй хүний гэр бүлийн хэрэгцээнд газар ашиглуулах шийдвэрийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

77.1.4.ашигт малтмал, газрын тос, байгалийн хий ашиглах зориулалтаар газар ашиглуулах гэрээ байгуулах шийдвэрийг улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

77.1.5.чөлөөт бүсд газар ашиглуулах шийдвэрийг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Чөлөөт бүсийн захирагчийн захиалгаар газрын биржээр дамжуулан нээлттэй дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулалтаар;

77.1.6.тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үндэслэн улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд аялал жуулчлал, судалгаа шинжилгээний зориулалтаар газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн.

77.2.Энэ хуулийн 77.1-д заасны дагуу газар ашиглах эрх авсан этгээдтэй газар ашиглуулах гэрээг дараах эрх бүхий байгууллага, албан тушаалтан 7 хоногт багтаан байгуулна:

77.2.1.энэ хуулийн 77.1.1, 77.1.2, 77.1.3, 77.1.4, 77.1.5-д заасны дагуу эрх авсан этгээдтэй газар ашиглуулах гэрээг тухайн шийдвэрийг гаргасан эрх бүхий байгууллага, албан тушаалтан байгуулж, ажлын 5 хоногт багтаан газрын эрхийн бүртгэлд бүртгүүлнэ;

77.2.2.чөлөөт бүс болон тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрхийг нээлттэй дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олж авсан этгээдтэй тухайн дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтыг захиалагч газар ашиглах гэрээ байгуулж, ажлын 5 өдөрт багтаан газрын эрхийн бүртгэлд бүртгүүлнэ.

77.3.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчийн газрыг гуравдагч этгээдэд ашиглуулах гэрээний нэгдсэн бүртгэлийг хөтөлж, хяналт тавина.

77.4.Газар ашиглуулах гэрээний эрх, үүргийг бусдад шилжүүлэх, газар ашиглах эрхээ барьцаалахыг хориглоно.

78 дүгээр зүйл.Газар ашиглуулах гэрээ болон газрын төлбөр

78.1.Төрийн өмчийн газрыг ашиглах гэрээг газар ашиглах журмын дагуу байгуулна. Газар ашиглах журмыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

78.2.Газар ашигласны төлбөрийн хэмжээ, хөнгөлөх, чөлөөлөх харилцааг Газрын төлбөрийн тухай хуулиар тогтооно.

78.3.Төрийн өмчийн газрыг төрийн болон орон нутгийн өмчит бусад этгээдэд ашиглуулах гэрээ төрд хохирол учруулахаар байж болохгүй.

79 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах

79.1.Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага, 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд /цаашид “төрийн байгууллага” гэх/-д үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай газрыг газар ашиглах гэрээгээр үнэгүй олгоно.

79.2.Энэ хуулийн 79.1-д заасан төрийн байгууллагад газар ашиглуулах гэрээг хугацаагүй байгуулна.

79.3.Төрийн байгууллага гэрээгээр ашиглаж буй газраа бусдад шилжүүлэх, барьцаалах, захиран зарцуулахыг хориглоно.

79.4.Төрийн байгууллага газар ашиглах хүсэлтээ энэ хуулийн 77.1.1-д заасан загварын дагуу дүүргийн газрын алба, сумын газрын даамалд гаргана.

79.5.Төрийн байгууллагад газар ашиглуулах гэрээ байгуулах асуудлыг аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон аймаг, нийслэлийн жилийн төлөвлөгөөг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

79.6.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тусгайлсан гэрээ байгуулах шийдвэрийг газрын кадастрын мэдээллийн санд тухай бүр бүртгэнэ.

79.7.Төрийн өмчийн газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга байгууламж барьж байгуулахад тухайн ажлыг гүйцэтгэгч этгээдэд газрын аливаа эрх олгохгүй.

80 дугаар зүйл.Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, гадаад улсын хуулийн этгээд, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газарт газар ашиглуулах

80.1.Гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, консулын газар, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газарт үндсэн чиг үүргээ болон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд нь зайлшгүй хэрэгцээтэй газрыг гэрээгээр ашиглуулж болно.

80.2.Гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, консулын газар, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газарт газар ашиглуулах нөхцөл, журмыг Монгол Улсын олон улсын гэрээгээр тогтооно.

80.3.Гадаадын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй гадаад улсын хуулийн этгээдэд хоёр талын болон олон талын гэрээгээр газар ашиглуулах нөхцөл, журмыг Засгийн газар тогтооно.

80.4.Гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, консулын газар, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газартай байгуулах газар ашиглах гэрээний хугацаа 30 жилийн хугацаатай байх бөгөөд гэрээний хугацааг энэ хуульд заасан журмын дагуу сунгаж болно.

80.5.Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллага, түүний төлөөлөгчийн газарт ашиглуулах гэрээний хугацаа болон төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай гэж үзвэл тухайн улстай харилцан адил байх зарчмыг баримтална.

80.6.Гадаадын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй гадаадын хуулийн этгээдтэй газар ашиглах гэрээг төсөл, хөтөлбөр хэрэгжих хугацаагаар байгуулна.

81 дугаар зүйл.Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах

81.1.Монгол Улсын иргэний гэр бүлийн хэрэгцээнд гэр, амьны орон сууц барих, өвөлжөө, хаваржааны дэвсгэр болон орчны газрыг төлбөртэйгөөр, гэрээгээр ашиглуулж болно.

81.2.Монгол Улсын иргэнд энэ хуулийн 82.1-д заасан зориулалтаар газар ашиглуулах гэрээ хугацаатай байна.

81.3.Монгол Улсын иргэний гэр бүлийн хэрэгцээнд ашиглуулах газрын хэмжээ нь энэ хуулийн 47.1-д заасан хэмжээтэй байна.

81.4.Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын аж ахуйн хэрэгцээнд нь дараах зориулалтаар газар ашиглуулж болно:

81.4.1.хадлан хадах, тариалах;

81.4.2.ашигт малтмал, газрын тос, байгалийн хий ашиглах;

81.4.3.судалгаа, хайгуул, шинжилгээ, туршилт, хэмжил зүйн үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний сорилт, туршилт явуулах;

81.4.4.худалдаа, үйлчилгээ явуулах;

81.4.5.хүлэмж, дарлага, зоорь, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хадгалах;

81.4.6.үйлдвэрлэл эрхлэх;

81.4.7.усан тээвэр хийх зорилгоор орчны газрыг ашиглах;

81.4.8. биеийн тамир, спортын зорилгоор спорт цогцолборын дэвсгэр газар, орчны талбайг ашиглах;

81.4.9.оршуулгын үйл ажиллагаа эрхлэх;

81.4.10.хог хаягдал цуглуулах;

81.4.11.ус түгээх;

81.4.12.эвдрэл бүхий газрыг нөхөн сэргээх, ойжуулах, цэцэрлэгжүүлэх.

81.5.Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад энэ хуулийн 81.4.3, 90.3.4-т заасан тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа эрхлэх зорилгоор газар ашиглах тохиолдолд гэрээний хугацаа нь тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаатай ижил байна. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах нь гэрээг сунгах үндэслэл болно.

81.6.Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, соёлын үзвэр үйлчилгээ үзүүлэх, кино, нэвтрүүлэг зэрэг оюуны бүтээл туурвих, улирлын чанартай судалгаа, хайгуул, шинжилгээ, туршилт, хэмжил зүйн үйл ажиллагаа, шинжлэх ухааны сорилт, туршилт явуулах зорилгоор газар ашиглахад тухайн үйл ажиллагааг зохион байгуулах ердийн боломжит хугацаагаар гэрээ байгуулна. Хэрвээ тухайн үйл ажиллагааг зохион байгуулах хугацаа тодорхойгүй бол газар ашиглах гэрээг 1 хүртэл жилийн хугацаатай байгуулна.

82 дугаар зүйл.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газар ашиглуулах

82.1.Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний гэр бүлийн хэрэгцээнд нь гэр, сууц, зуслангийн газрыг гэрээгээр төлбөртэй ашиглуулж болно.

82.2.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд гэрээгээр ашиглуулах газрын хэмжээ 0,05 га-аас илүүгүй байна.

82.3.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газар ашиглуулах гэрээг 5 хүртэл жилийн хугацаатай байгуулна. Энэ хугацааг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр нэг удаад 5 жилийн хугацаагаар сунгана.

82.4.Байгалийн гамшиг, халдварт өвчин, хөл хорионы улмаас дамжин нүүдэллэх, түр оршин суух этгээдэд газар ашиглуулах гэрээг 1 хүртэл жилийн хугацаатай байгуулна.

83 дугаар зүйл.Уул уурхай, ашигт малтмал, газрын тос, байгалийн хий ашиглах зориулалтаар газрыг гэрээгээр ашиглуулах

83.1.Уул уурхай, ашигт малтмал, газрын тос, байгалийн хий ашиглах зориулалтаар ашиглуулах боломжтой газрын байршлыг улс, аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгана.

83.2.Уул уурхай, ашигт малтмал, газрын тос, байгалийн хий ашиглах, тусгай зөвшөөрөл эзэмшигч уг зөвшөөрлийг авснаас хойш 30 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээтэй газрыг ашиглах хүсэлтээ аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

83.3.Уул уурхай, ашигт малтмал, газрын тос, байгалийн хий ашиглах, хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдтэй энэ хуулийн 79.5-д заасан эрх бүхий байгууллага газар ашиглуулах гэрээ байгуулна.

83.4.Уул уурхай, ашигт малтмал, газрын тос, байгалийн хий ашиглах, хайгуул хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд тусгай зөвшөөрөлтэй талбайн орчимд уурхайн хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах газрыг дуудлага худалдааны анхны үнээр тусгай зөвшөөрлийн хугацаагаар ашиглуулж болно.

83.5.Энэ хуульд заасны дагуу гэрээгээр ашиглуулах газар нь ашигт малтмал ашиглахтай холбогдуулан барилга байгууламж барих, зам, шугам сүлжээ татах үйл ажиллагаа явуулахад шаардагдах хэмжээтэй байна.

83.6.Газрын тос болон Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайд бусад этгээдэд газар өмчлүүлэх, газрын эрхээр болон гэрээгээр ашиглуулахыг хориглоно.

83.7.Ашигт малтмал, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газрын тосны ашиглалтын талбайн хэмжээг баталгаажуулсан холбогдох шийдвэрийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

83.8.Ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулахад энэ хууль болон Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг дагаж мөрдөнө.

84 дүгээр зүйл.Чөлөөт бүсэд газар ашиглуулах

84.1.Чөлөөт бүсэд газрыг дараах чиглэл, зориулалтаар ашиглуулж болно:

84.1.1.хилийн боомтын гаалийн чөлөөт бүсийн газар ("франко" бүс);

84.1.2.экспорт импортын аж үйлдвэрийн паркийн чөлөөт бүсийн газар;

84.1.3.чөлөөт худалдааны чөлөөт бүсийн газар;

- 84.1.4. хамтарсан бизнесийн чөлөөт бүсийн газар;
- 84.1.5. инноваци технологийн паркийн чөлөөт бүсийн газар;
- 84.1.6. оффшор банк, санхүүгийн үйлчилгээний чөлөөт бүсийн газар;
- 84.1.7. аялал жуулчлалын үйлчилгээний чөлөөт бүсийн газар;
- 84.1.8. эдийн засгийн цогцолборын /холимог/ чөлөөт бүсийн газар.

84.2. Чөлөөт бүсэд ашиглуулах газрын байршил, хэмжээг чөлөөт бүсийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, түүний бүсчлэлийн шаардлага, дүрэмд нийцүүлэн чөлөөт бүсийн захирагч тогтооно.

84.3. Чөлөөт бүсэд газрыг энэ хуульд заасан зориулалтаар төсөл сонгон шалгаруулалт, эсхүл дуудлага худалдаагаар хөрөнгө оруулагч этгээдэд 15 жилийн хугацаагаар ашиглуулна. Чөлөөт бүсийн газрыг ашиглуулах гэрээг нэг удаад 15 жилийн хугацаагаар сунгана.

85 дугаар зүйл. Газар ашиглаж буй этгээдийн нийтлэг үүрэг

85.1. Газар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах үүрэг хүлээнэ:

85.1.1. газрыг гэрээнд заасан нөхцөл, зориулалтын дагуу ашиглах, газрын төлөв байдал, чанарыг доройтуулахгүй байх;

85.1.2. газар ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөх;

85.1.3 газрыг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх;

85.1.4. газрын хэвийн байдлыг хангахад шаардлагатай зардлыг хариуцах;

85.1.5. газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглахтай холбогдуулан тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, газрын төлөв байдал, чанарыг доройтуулсан бол учруулсан хохирлыг тогтоосон журмын дагуу нөхөн төлөх;

85.1.7. тухайн газрыг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гарсан бол хуульд заасан хугацаанд газрыг үл маргах журмаар чөлөөлөх;

85.1.8. гэрээний хугацаа дуусахад газрыг хүлээлгэн өгөх.

86 дугаар зүйл. Газар ашиглуулах гэрээ дуусгавар болох

86.1. Газар ашиглуулах гэрээг дараах тохиолдолд дуусгавар болгоно:

86.1.1. газар ашиглагч иргэн нас барсан, нас барсанд тооцсон, эсхүл сураггүй алга болсонд тооцсон шийдвэр;

86.1.2. газар ашиглагч хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан;

86.1.3. газар ашиглах үндэслэл болсон тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;

86.1.4. газар ашиглах гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон;

86.1.5. эрх бүхий этгээдийн шийдвэрээр гэрээг цуцалсан;

86.1.6. газар ашиглагч гэрээгээ цуцлах хүсэлт гаргасан;

86.1.7.тусгай хэрэгцээнд авах, эсхүл өөр газраар солих, эргүүлэн авахаар тохиролцож гэрээ байгуулсан;

86.1.8.газар ашиглах шийдвэрийг хүчингүй болгох шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан.

87 дугаар зүйл. Газар ашиглуулах гэрээг цуцалж, шийдвэрийг хүчингүй болгох

87.1.Эрх олгосон этгээд газар ашиглуулах гэрээг дараах үндэслэлээр цуцалж, шийдвэрийг хүчингүй болгоно:

87.1.1.хууль бус баримт бүрдүүлэх, хууран мэхлэх замаар шийдвэр гаргуулсан нь тогтоогдсон;

87.1.2.бусдад дамжуулан ашиглуулсан;

87.1.3.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж барих оролдлого хийсэн;

87.1.4.газрыг нийгмийн зайлшгүй шаардлагаар, нийтийн зориулалтаар ашиглахаар шийдвэрлэсэн;

87.1.5.газрыг зориулалтын дагуу 1 жилийн хугацаанд ашиглаагүй;

87.1.6.газар ашиглах төлбөрийг 1 жилийн хугацаанд төлөөгүй;

87.1.7.энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан журмын дагуу газрыг тусгай хэрэгцээнд авсан;

87.1.8.газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласныг эрх бүхий байгууллага дүгнэлтээр тогтоогдсон;

87.1.9.газар ашиглах шийдвэр гаргасан эрх бүхий байгууллага болон шүүхийн шийдвэрээр гэрээг хүчингүй болгосон.

87.2.Газар ашиглах гэрээг энэ хуулийн 88.1.6-т заасан үндэслэлээр хүчингүй болгох шийдвэр гарсны дараа газар ашигласны төлбөрөө төлсөн нь эрхийг сэргээх үндэслэл болохгүй.

87.3.Газар ашиглах гэрээг хүчингүй болгох шийдвэрийн талаар газар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон газар ашиглах зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээдэд ажлын 5 өдрийн дотор мэдэгдэнэ.

88.4.Энэ хуулийн 87.1-д заасан мэдэгдэл өгснөөс хойш ажлын 10 өдрийн дотор газар ашиглуулах зөвшөөрөл олгосон этгээд гэрээг цуцалж, энэ талаар газрын эрхийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.

87.5.Энэ зүйлийн 88.1-д зааснаар гэрээг цуцлах шийдвэр гарсан бол газар ашиглах гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсантай холбоотой нөхөн олговрыг төрөөс олгоно.

88 дугаар зүйл. Газар чөлөөлөх, нөхөн сэргээх

88.1.Газар ашиглуулах гэрээ дуусгавар болсон, эсхүл гэрээг хүчингүй болгосон бол ашиглагч ашиглалтын ердийн элэгдэл, хорогдлыг эс тооцон газрыг ашиглахаас өмнөх байдалд нь сэргээн газар ашиглуулах гэрээ байгуулсан эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

88.2.Энэ хуулийн 95.1.9-т заасан үндэслэлээр газар ашиглах зөвшөөрлийг хүчингүй болгосон бол гэм буруутай этгээд барилга байгууламжийг өөрийн зардлаар нураах буюу нүүлгэн шилжүүлж газрыг чөлөөлөх, газрын зориулалтыг

өөрчлөхөөс өмнөх байдалд сэргээн оруулж, учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

88.3.Газар ашиглуулах гэрээ дуусгавар болоход тухайн газартай салшгүй бэхлэгдсэн барилга байгууламжийг нүүлгэн шилжүүлэх боломжгүй, барилгын ашиглалтын ердийн боломжит хугацаа дуусаагүй тохиолдолд төр тухайн үл хөдлөх хөрөнгийн балансын үнээс элэгдэл, хорогдлыг хассан, бодит зардлаар үнийг төлж, өмчлөх эрхийг шилжүүлэн авч болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ГАЗРЫН БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАЗРЫН ДУУДЛАГА

ХУДАЛДАА, ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

89 дүгээр зүйл. Газрын бирж

89.1. Газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх байгууллага энэ хуулийн 25.2.3-т заасан системийг ашиглан эрхэлнэ.

89.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын биржийн арилжааг энэ хуулийн 90.1-д заасан этгээд зохион байгуулна.

89.3. Газрын бирж /цаашид “бирж” гэх/ нь газрын эрхийн арилжааг зохион байгуулахдаа бие даасан, нээлттэй, ил тод, хараат бус, тэгш оролцоог хангасан, сайн дурын байх зарчмыг баримтална.

89.4. Газрын бирж нь зориулалтын байр, төвлөрсөн мэдээллийн сантай байх бөгөөд биржийн арилжааг зохион байгуулах программ хангамж, сүлжээний найдвартай байдлыг хангасан байна.

89.5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал хариуцсан нэгж, Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд газрын хязгаарлагдмал эрх олгохтой холбоотой үйл ажиллагааг газрын цахим биржээр дамжуулан хэрэгжүүлнэ.

90 дугаар зүйл. Биржийн чиг үүрэг

90.1. Газрын бирж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

90.1.1. төрийн өмчийн газрыг иргэний өмчлөлд шилжүүлэх болон газрын узуфрукт, төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг олгох дуудлага худалдааг зохион байгуулах;

90.1.2. төрийн өмчийн газар дээр барилга байгууламж барих эрхийг олгох төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах;

90.1.3. гэрээний үндсэн дээр иргэний өмчийн газрыг арилжаалах, зуучлах;

90.1.4. газрын арилжааны зах зээлийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах

90.1.5. төрийн өмчийн газрын хувьцааг арилжих;

90.1.6. газар хөгжүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх сан бүрдүүлэх, газрын хөгжүүлэх;

90.1.7.газрын биржийн үйл ажиллагаанд оролцогчийг бүртгэх, эрх олгох, эрхийг түдгэлзүүлэх, цуцлах;

90.1.8.газрын биржийн арилжаанд оролцогчийг сургах, шаардлагатай мэдээллээр хангах;

90.1.9.газрын биржийн арилжааны явцад хяналт тавих, хууль бус үйл ажиллагаанд таслан зогсоох;

90.1.10.газрын зах зээлийн үнийн судалгаа тогтмол хийж мэдээллийн санг бүрдүүлэх, бүртгэл хөтлөх, олон нийтэд үнэ ханшийн мэдээллээр үйлчлэх, биржийн мэдээллийн сангаас лавлагаа олгох;

90.1.11.энэ хууль, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын журмыг баримтлан газрын дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулах ажиллагааг удирдан зохион байгуулж, ялагчийн мэдээллийг орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон захиалга өгсөн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

90.1.12.газрын зах зээлийн үнийн мэдээллийн сангийн мэдээллийг тухай бүр шинэчлэх, мэдээлэл хүссэн иргэн, хуулийн этгээдэд холбогдох мэдээллийг журмын дагуу өгөх;

90.1.13.газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явагдсан газрын нэгж талбар бүрд хувийн хэрэг нээж, холбогдох баримт бичгүүдийн хамт кадастрын мэдээллийн санд цахим болон цаасан хэлбэрээр хадгалах;

90.1.14.биржийн үйл ажиллагааны тайлан, мэдээг сар бүр нэгтгэж, статистик тоон үзүүлэлтийг нээлттэй мэдээлэх;

90.1.15.биржийн оролцогчийн үйл ажиллагааг зохицуулах;

90.1.16.биржийн дэнчингийн хувь хэмжээг тогтоох;

90.1.17.иргэн, хуулийн этгээдийн газрыг нөхөн олговортойгоор эргүүлэн авах;

90.1.18.төрийн өмчийн газраас нөөцөд авах замаар газар зохион байгуулалт хийж, газрын нөөц бүрдүүлэх;

90.1.19.доройтолд орсон газрыг нөхөн сэргээх;

90.1.20.газрын удирдлагын цахим системийг хөгжүүлэх;

90.1.21.газар зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

90.1.22.хууль болон журмаар хүлээсэн бусад чиг үүрэг.

90.2.Газрыг хөгжүүлэх, төрийн өмчийн газраас нөөцөд авах үйл ажиллагаа нь газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн байна.

91 дугаар зүйл.Биржийн харилцаанд оролцогч

91.1.Биржийн харилцаанд зөвхөн Монгол Улсын иргэн, хуулийн этгээд оролцоно.

91.2.Газрын биржийн харилцаанд дараах этгээд оролцохыг хориглоно:

91.2.1.газрын биржийн ажилтан;

91.2.2.даатгал, тусламжийн сан, тэдгээрийн ажилтан;

91.2.3.гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хуулийн этгээд, олон улсын байгууллага;

91.2.4.хууль тогтоомжоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон бусад этгээд.

92 дугаар зүйл.Биржийн удирдах зөвлөл

92.1.Биржийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, биржийн арилжааны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааны уялдааг хангах чиг үүрэг бүхий орон тооны бус удирдах зөвлөл ажиллана.

92.2.Биржийн удирдах зөвлөл нь 7 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 5 гишүүн нь газар, санхүү, эдийн засаг, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагыг, 2 гишүүн нь газрын арилжааны зах зээлд оролцогчдыг төлөөлсөн төрийн бус байгууллагыг тус тус төлөөлнө.

92.3.Биржийн удирдах зөвлөлийн гишүүнийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санал болгосноор газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

92.4.Удирдах зөвлөлийн дарга нь газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл байх бөгөөд газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

92.5.Биржийн үйл ажиллагааны журам болон зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг газрын болон Сангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

93 дугаар зүйл.Биржийн үйл ажиллагааны санхүүжилт

93.1. Биржийн үйл ажиллагааг доор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 93.1.1.улсын төсвөөс олгох санхүүжилт;
- 93.1.2.орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт;
- 93.1.3.биржийн үйл ажиллагааны орлогын 30 хувь;
- 93.1.4.газрын төлбөрийн орлогын 30 хувь;
- 93.1.5.амжилтгүй болсон газрын дуудлага худалдааны дэнчин;
- 93.1.6.үйлчилгээний хураамж;
- 93.1.7.газрын биржээс үзүүлэх үйлчилгээнээс олсон орлого;
- 93.1.8.хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр;
- 93.1.9.иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив.

93.2.Бирж нь үйл ажиллагааны орлого төвлөрүүлэх, зарцуулах данстай байна.

94 дүгээр зүйл.Газар хөгжүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх сан

94.1.Бирж нь иргэн, хуулийн этгээдийн газрыг нөхөн олговортойгоор эргүүлэн авах, төрийн өмчийн газраас нөөцөд авах замаар газар зохион байгуулалт хийх, газрын нөөц бүрдүүлэх, чанарын доройтолд орсон газрыг нөхөн сэргээх ажлыг газар хөгжүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх сангаас санхүүжүүлнэ.

94.2.Газрыг хөгжүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх сангийн үйл ажиллагааны журмыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

94.3.Газар хөгжүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

94.3.1.энэ хуулийн 94.1-д заасан газрын биржийн үйл ажиллагааны орлого;

94.3.2.газар хөгжүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив;

94.3.3.хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад орлого.

94.4.Газрыг хөгжүүлэх, төрийн өмчийн газраас нөөцөд авах үйл ажиллагаа нь газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн байна.

95 дугаар зүйл.Газрын дуудлага худалдаа

95.1.Газрын дуудлага худалдаа /цаашид “дуудлага худалдаа” гэх/ гэж дуудлага худалдааны нөхцөл, нэмэлт нөхцөлийг хүлээн зөвшөөрч, хамгийн өндөр үнэ хэлж ялагч болсон этгээдэд газар өмчлөх эрх, газрын хязгаарлагдмал эрх болон гэрээгээр газар ашиглах эрхийг олгох ажиллагааг ойлгоно.

95.2.Дуудлага худалдааг улс, аймаг, нийслэл, сумын жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн бирж цахимаар үнэ хаялцуулах аргаар нээлттэй зохион байгуулна.

95.3.Дуудлага худалдааны журмыг Засгийн газар, газрын дуудлага худалдааны анхны үнэ тооцох аргачлалыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

96 дугаар зүйл.Төсөл сонгон шалгаруулалт

96.1.Засгийн газраас баталсан тэргүүлэх чиглэлийн үйлдвэр бүтээн байгуулалтын томоохон төсөл, арга хэмжээ болон орон сууцны хотхон барихад зориулж төрийн өмчийн газарт төсөл сонгон шалгаруулалтын журмаар газрын хязгаарлагдмал эрх болон газрыг гэрээгээр ашиглах эрх олгоно.

96.2.Төрийн өмчийн газар дээр тэргүүлэх чиглэлийн үйлдвэр болон орон сууцны хотхон барих эрхийг төсөл сонгон шалгаруулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно. Төсөл сонгон шалгаруулалтыг улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн газрын бирж зохион байгуулна.

96.3.Газрын эрх олгох төсөл, сонгон шалгаруулалтын журмыг Засгийн газар батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ

КАДАСТР

97 дугаар зүйл. Кадастр, түүний агуулга, төрөл

97.1.Кадастр нь газрын нэгдмэл сангийн бүх ангилал, төлөв байдал чанар, чадавх, нэгж талбар, дэд талбарт суурилсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн эрх, эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох, хил зааг, хаяг, байршил, үнэлгээ, татвар, төлбөр, хураамжийн мэдээллийг агуулсан бүртгэлийг эрхлэх, хэрэглэгчдэд байнга хүргэх зорилго бүхий байнга шинэчлэгдэж байдаг үйл ажиллагаатай мэдээллийн нэгдсэн систем бөгөөд газар, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн суурь байна.

97.2.Кадастрын бүртгэлийн систем нь нэгж талбарт суурилсан Монгол Улсын нийт газар нутаг, түүний хэвлий, газрын дээрх болон доорх үл хөдлөх эд хөрөнгө, хаяг, иргэн, хуулийн этгээдийн газрыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дагуу цогцоор нь бүртгэнэ.

97.3.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах төрлийн кадастрыг улсын хэмжээнд цахимаар эрхэлнэ:

97.3.1. нөөцийн кадастр;

97.3.2. эрхийн кадастр;

97.3.3. хот байгуулалтын кадастр;

97.3.4. санхүүгийн кадастр.

97.4.Нөөцийн кадастрт газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангиллын газрыг газар ашиглах зориулалтаар нь зураглах, тоо бүртгэл хөтлөх, өөрчлөлт оруулах, газрын төлөв байдал, чанар, чадавхын бүртгэлд хамаарах үзүүлэлтийг тодорхойлж бүртгэл хөтлөх үйл ажиллагаа хамаарна.

97.5.Эрхийн кадастрт нэгж талбарт суурилсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн харилцаа, эрхийн хязгаарлалт, тэдгээрт хамаарах үзүүлэлтийг тодорхойлж бүртгэл хөтлөх үйл ажиллагаа хамаарна.

97.6.Хот байгуулалтын кадастрт газрын гадарга дээр болон доор орших зам талбайн, ногоон байгууламжийн, барилга байгууламжийн, газар дээрх болон доорх инженерийн шугам сүлжээний, гэр хорооллын, инженер геологийн, ус, ус сувгийн зориулалтаар нь зураглах, тоо бүртгэл хөтлөх, өөрчлөлт оруулах, газрын төлөв байдал, чанар, чадавхын бүртгэлд хамаарах үзүүлэлтийг тодорхойлж бүртгэл хөтлөх үйл ажиллагаа хамаарна.

97.7.Санхүүгийн кадастрт газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, татвар, төлбөр, хураамж, тэдгээрт хамаарах бүсчлэл, үзүүлэлтийг тодорхойлж бүртгэл хөтлөх үйл ажиллагаа нь хамаарна.

97.8.Кадастрын үйл ажиллагаа, түүнийг эрхлэхтэй холбоотой харилцааг Кадастрын тухай хуулиар зохицуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН МОНИТОРИНГ, ХЯНАН БАТАЛГАА

98 дугаар зүйл.Газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгаа хийх

98.1.Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын тогтвортой, гол үзүүлэлтүүдийг хууль тогтоомжид заасан хугацаанд давтан тодорхойлж улсын хяналтад авсан анхны үзүүлэлтүүдтэй харьцуулахыг газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгаа гэнэ.

98.2.Газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааны объект нь Монгол Улсын газрын нэгдмэл сан байна.

98.3.Газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

98.3.1.бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдоогүй төрийн өмчийн газрын төлөв байдал, чанарыг мониторингийн сүлжээ байгуулж эрхлэх замаар;

98.3.2.бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын төлөв байдал, чанарыг хянан баталгаа хийх замаар.

98.4.Газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгаа хийх журмыг Засгийн газар, ажлын норм, үнэлгээг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

98.5.Газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааны мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, түгээх, мэдээллийн нэгдсэн сан, системтэй байх бөгөөд системийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэнэ.

98.6.Газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааны систем нь энэ хуулийн 25.2-т заасан газрын удирдлагын цахим системийн бүрэлдэхүүн хэсэг байна.

98.7.Газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааны системийг ажиллуулах журмыг газрын болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг тусган газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

98.8.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газрын төлөв байдал, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох, хянах хяналтын лаборатортой байна.

98.9.Газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааг дараах ерөнхий үзүүлэлтийн өөрчлөлтөөр гаргана:

98.9.1.газрын гадаргын төрх байдал;

98.9.2.ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, ургац, бүрхэвч;

98.9.3.хөрсний үржил шимт үе давхаргын зузаан;

98.9.4.хөрсний ялзмагийн агууламж;

98.9.5.хөрсний бохирдол.

98.10.Энэ хуулийн 115.9-д заасан үзүүлэлт дээр тухайн газар ашиглалтын байдал, онцлогийг харгалзан нэмж хэрэглэх үзүүлэлт, тэдгээрийг тодорхойлох журмыг газрын болон холбогдох төрийн захиргааны байгууллагын саналыг тусган газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

98.11.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх авсан мэргэжлийн байгууллага газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааг гүйцэтгэж, дүгнэлт гарган, хариуцлага хүлээнэ.

98.12.Дараах этгээд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны шинжээч байна:

98.12.1.энэ хуулийн 22.2-т заасан этгээд, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь улсын ерөнхий шинжээч;

98.12.2. энэ хуулийн 22.2-т заасан аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь байнгын шинжээч.

98.13.Улсын ерөнхий шинжээч нь дараах газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааны үр дүн, дүгнэлтийг баталгаажуулна:

98.13.1.улсын тусгай хэрэгцээний газрын;

98.13.2.аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг дамнан байрласан нэгж талбарын;

98.13.3. ашигт малтмал, газрын тосны нэгж талбарын;

98.13.4. тариалан, атаршсан газрын.

98.14.Байнгын шинжээч энэ хуулийн 115.13-т зааснаас бусад газрын төлөв байдлын, чанарын хянан баталгааны үр дүн, дүгнэлтийг баталгаажуулна.

99 дугаар зүйл.Газрын төлөв байдал, чанарын мониторинг

99.1.Газрын төлөв байдал, чанарын мониторингийг хэрэгжүүлэхдээ байгаль, газар зүй, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан байнгын ажиглалт, судалгаа хийх талбар, цэгийг сонгож, мониторингийн сүлжээг байгуулна.

99.2.Газрын төлөв байдал, чанарын мониторингийн цэг нь 1, 2 гэсэн зэрэглэлтэй байна.

99.3.Тухайн нутаг дэвсгэрийг бүрэн төлөөлж чадахуйц, тогтвортой, байнгын ажиллагаатай цэгийг 1 дүгээр зэрэглэлд хамруулна.

99.4.Байгаль, цаг уурын өөрчлөлт, газар ашиглалтыг харгалзан газрын төлөв байдал, чанарт ноцтой өөрчлөлт гарсан, гарах магадлалтай газруудад хөдөлгөөнтэй байдлаар хэмжилт хийх цэгийг 2 дугаар зэрэглэлд хамруулна.

99.5.Бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын хүрээнд тодорхойлогдсон цэгийн мэдээллийг газрын төлөв байдал, чанарын мониторинг хийхэд нэмэлтээр ашиглана.

99.6.Газрын төлөв байдал, чанарын мониторингийн 1 дүгээр зэрэглэлийн цэгийн тоо, байршил, хэмжилт хийх хуваарийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

99.7.Газрын төлөв байдал, чанарын мониторингийн 2 дугаар зэрэглэлийн цэгийн тоо, байршил, хэмжилт хийх хуваарийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

99.8.Газрын төлөв байдал, чанарын мониторингийг эрхлэхдээ зайнаас тандан судлах болон газар дээр нь хэмжилт хийх аргыг хослуулан ашиглана.

99.9.Газрын төлөв байдал, чанарын мониторингийн 1 дүгээр зэрэглэлийн цэг дээр хэмжилт хийх ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллага, 2 дугаар зэргийн цэг дээр хэмжилт хийх ажлыг аймаг, нийслэл, дүүрэгт газрын алба, суманд газрын даамал хариуцна.

99.10.Газрын төлөв байдал, чанарын мониторингийн үр дүнг мониторингийн мэдээллийн нэгдсэн санд дараах байгууллагууд доор дурдсан хугацаанд оруулна:

99.10.1.бэлчээр, тариалангийн газрын төлөв байдал, чанарын мониторингийн үр дүнг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, цаг уур орчны шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран жил бүрийн 10 дугаар сарын 01-нээс өмнө;

99.10.2.хот, суурин газрын төлөв байдал, чанарын мониторингийн үр дүнг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, цаг уур, орчны шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүрийн 10 дугаар сарын 01-нээс өмнө;

99.10.3.ойн сан болон усны сан бүхий газрын төлөв байдал, чанарын мониторингийн үр дүнг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс өмнө.

99.11.Газрын төлөв байдал, чанарын мониторингийн мэдээллийн эх үүсвэр нь байнгын ажиглалтын зураглал, судалгаа, газар ашиглалт хамгаалалтын улсын тоо

бүртгэл, хяналт шалгалтын материал, газрын төлөв байдал, чанарын судалгааны мэдээллийн сан, архивын материал бусад баримт бичгээс бүрдэнэ.

99.12.Засгийн газраас баталсан журам, холбогдох байгууллагын хамтран баталсан аргачиллын дагуу газрын төлөв байдал, чанарын мониторинг, үнэлгээнд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрээр жил бүрийн 12 дугаар сарын 10-аас өмнө гаргана.

99.13.Хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт хүргүүлж, хэрэгжилтэд нь дараа оны үр дүнгээр хяналт тавина.

99.14.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар хэрэгжүүлэх арга хэмжээг газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

99.15.Газрын төлөв байдал, чанарын мониторингийн үр дүн, тайланг Улсын Их Хуралд 5 жил тутам, Засгийн газарт 2 жил тутам танилцуулна.

99.16.Газрын төлөв байдал, чанарын мониторинг нь байгаль орчны бусад мониторингийг эрхлэх эх суурь болох бөгөөд төрөөс газрын нөөцийг удирдах чиг үүргийг гүйцэтгэх, газар зохион байгуулалт, газрын кадастр эрхлэх, газар ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн байдалд хяналт тавих, гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, бодлого боловсруулах, шийдвэр гаргах үндэслэл болно.

100 дугаар зүйл.Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа

100.1.Анх удаа олгох газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн үр дүнг ашиглан аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, дүүргийн газрын алба, сумын даамал үнэ төлбөргүйгээр гаргаж, гэрээнд хавсаргана.

100.2.Газрын эрхтэй этгээд, газар ашиглагч нь газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр 5 жил тутам хийлгэх бөгөөд дараах тохиолдолд хугацаа харгалзахгүй хийлгэнэ:

100.2.1.газрын эрхийн хугацаа дуусгавар болоход;

100.2.2.газрын эрхээ бусдад шилжүүлэхэд;

100.2.3.газрын эрхийн хугацааг сунгуулахад;

100.2.4.тухайн шатны Засаг дарга, эрх бүхий этгээд болон газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр.

100.3.Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт нь газрын эрхийг баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлах, сэргээх, гэрээ байгуулах, дүгнэх, өөрчлөлт оруулах, газарт учруулсан хохирлыг тооцох, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд төрөөс хяналт тавих үндэслэл болно.

101 дүгээр зүйл.Газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааны санхүүжилт

101.1.Бэлчээр, тариалан, атаршсан газар, аймаг, нийслэлийн хил дамнан томоохон бүтээн байгуулалт хийх газар, улсын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааны ажлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

101.2.Ашигт малтмалын газрын газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааны ажлын зардлыг тухайн зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

101.3.Орон нутгийн тусгай хэрэгцээний болон хот, тосгон бусад суурины газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ

ГАЗРЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ

102 дугаар зүйл.Газар ашиглагчийн газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх нийтлэг үүрэг

102.1.Газрын эрхтэй этгээд болон газар ашиглагч нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

102.1.1.газрын төлөв байдал, чанар алдагдах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагших, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хэрэгжүүлэх;

102.1.2.ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос олборлох, тээвэрлэх, барилгын материал бэлтгэх, төмөр зам, авто зам тавих, эрэл хайгуул, сорилт туршилт, шинжилгээний ажил хийх болон бусад зориулалтаар ухаж ашигласнаас элэгдэж, эвдэрч гэмтсэн газрыг тухай бүр өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээж, засаж тохижуулах;

102.1.3.газар, түүний баялаг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахдаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;

102.1.4.өвөрмөц экосистем, ойн төгөл, усны сан бүхий газар, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын үл хөдлөх дурсгал зүйл бүхий газрыг хамгаалах.

102.2.Энэ хуулийн 119 дүгээр зүйлд заасан үүргийн хэрэгжилтийг холбогдох төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан зохион байгуулж, хяналт тавина.

102.3.Газарт учруулсан хохирлын хэмжээг тооцох, нөхөн төлбөр төлөх журмыг газрын болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

103 дугаар зүйл.Газар ашиглах үеийн эрүүл ахуй, аюулгүй байдалд тавигдах шаардлага

103.1.Иргэн, хуулийн этгээд нь газар ашиглахтай холбоотой зураг төсөл боловсруулах, шинэ технологи нэвтрүүлэх, Монгол Улсад өмнө нь сорьж, шалгаагүй технологи, төрөл бүрийн химийн бодис, бордоо, газарт хэрэглэхийн тулд эрх бүхий мэргэжлийн байгууллагаар байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэнэ.

103.2.Иргэн, хуулийн этгээд нь байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулахыг хориглох ба үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагын зөвшөөрлийг үндэслэн гүйцэтгэнэ.

103.3.Иргэн, хуулийн этгээд нь энэ хуулийн 103.1-д заасан ажлыг гүйцэтгэхийн өмнө энэ тухайгаа тухайн шатны мэргэжлийн хяналтын газар, газрын албанд урьдчилан мэдэгдэж, хүн амд мэдээлэн, уг газрын заагийг тэмдэгжүүлж, сэрэмжлүүлэх байнгын харуул ажиллуулах, дохио тэмдэгтүүдийг байрлуулах ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.

103.4.Иргэн, хуулийн этгээд нь өөрийн газартаа барилга барих, орчныг тохижуулахдаа аюулгүй байдлыг хангаж барилгажилтын норм, дүрмийг биелүүлэх үүрэгтэй.

104 дүгээр зүйл. Газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах

104.1.Газрын хэвлийг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан байна.

104.2.Улсын Их Хурал улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг, эсхүл хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахыг хязгаарлах буюу хориглох бүсийг тогтооно.

104.3.Аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний төсөлд ашигт малтмал, газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээнд санал өгнө.

104.4.Ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайг гэрээгээр ашиглуулах асуудлыг улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэж, дүүргийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон сумын газрын даамал өргөдлийн дагуу газар ашиглах гэрээ байгуулна.

104.5.Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд уул уурхайн олборлолт явуулах, үйлдвэрлэл, суурьшлын бүсийн газар, тээвэрлэлт, технологийн зам, гүүр бусад холбогдох барилга байгууламж барих газрыг тусган батлуулж, газар ашиглах гэрээ байгуулна.

104.6.Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад дундын мэдээллийн сантай байна.

104.7.Энэ хуулийн 121.6-д заасан дундын мэдээллийн сангаар дамжуулан ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газар ашиглах гэрээ, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний мэдээллийг харилцан солилцоно.

104.8.Ашигт малтмал, газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий газрын төлбөрийн асуудлыг Газрын төлбөрийн тухай хуулиар зохицуулна.

104.9.Газрын хэвлийг ашиглагч нь газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэж түүнд үндэслэн газрыг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөтэй байна.

104.10.Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөний гүйцэтгэлийг аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сумын газрын даамал жил бүр дүгнэж, дүнг нэгтгэн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад танилцуулна.

104.11.Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйтэтгэхээс бусад тохиолдолд ашигт малтмал, газрын тосны ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрлийг дараах газартай давхацуулан олгохыг хориглоно:

104.11.1.атар газрын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газар;

104.11.2.гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар;

104.11.3.хот, тосгон, бусад суурины эдэлбэр газар;

104.11.4.улсын тусгай хамгаалалттай газар нутгийн дархан цаазат газрын ангилалд хамаарах газар.

104.12.Иргэн хуулийн этгээдийн газрын хязгаарлагдмал эрхээр эзэмшиж, ашиглаж байгаа болон иргэний өмчийн газар нь ашигт малтмал, газрын тос ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайтай давхацсан тохиолдолд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохын өмнө тухайн иргэн, хуулийн этгээдтэй тохиролцож нөхөх олговрын асуудлыг шийдвэрлэнэ.

105 дугаар зүйл.Бэлчээрийн газрын харилцаа, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх

105.1.Бэлчээр ашиглах, хамгаалах асуудлыг энэ хуулийн 27.1-т заасан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний баримт бичигт үе шаттайгаар төлөвлөж, хэрэгжүүлнэ.

105.2.Бэлчээрийн газрыг дараах байдлаар ангилна:

105.2.1.улирлын бэлчээр (өвөл, хавар, зун, намрын);

105.2.2.отрын нөөц бэлчээр;

105.2.3.эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бэлчээр;

105.2.4.мал нүүдэллэх зурвас газар;

105.2.5.байгалийн тогтоцоор бий болсон гол, горхи, нуур, цөөрөм, хужир мараа, уст цэг бүхий бэлчээр.

105.3.Энэ хуулийн 123.2.2-т зааснаас бусад бэлчээрийн газрын хил заагийг аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр тогтоох бөгөөд төлөвлөгөө иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсанаар газрын нэгдмэл сангийн ангилалд өөрчлөлт оруулна.

105.4.Газар нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал болон түүнийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан бэлчээрийн газрыг гэрээгээр болон нийтээр ашиглана.

105.5.Энэ хуулийн 123.2.1, 123.2.12-т заасан бэлчээрийг гэрээгээр, 123.2.4, 123.2.5-т заасан бэлчээрийг нийтээр ашиглуулна.

105.6.Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу бэлчээрт ашиглаж болно.

105.7.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн Засгийн газар тогтооно.

105.8.Монгол Улсын нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувь нь отрын нөөц бэлчээр байна.

105.9.Отрын нөөц бэлчээрт доор дурдсан бэлчээр хамаарна:

105.9.1.аймаг дундын отрын нөөц бэлчээр;

105.9.2.сум дундын отрын нөөц бэлчээр;

106.9.3.сумын отрын нөөц бэлчээр.

105.10.Отрын нөөц бэлчээрийн хэмжээ, хил заагийг хамаарах нутаг дэвсгэрийн бэлчээр ашиглагчдын санал, багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэр, тухайн шатны Засаг даргын санал, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн доор дурдсан этгээд тогтооно:

105.11.аймаг дундын отрын нөөц бэлчээрийн хэмжээ, хил заагийг Засгийн газар;

105.11.1.сум дундын отрын нөөц бэлчээрийн хэмжээ, хил заагийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

105.11.2.сумын отрын нөөц бэлчээрийн болон нүүдэллэн оторлох бэлчээрийн хэмжээ, хил заагийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал.

105.12.Отрын нөөц бэлчээрт мал оруулах, бэлчээрээс гаргах асуудлыг бэлчээрийн мониторинг, бэлчээрийн даацын мэдээллийг доор дурдсан этгээд шийдвэрлэнэ:

105.12.1.аймаг дундын отрын нөөц бэлчээрт тухайн аймгийн Засаг даргатай зөвшилцөн хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

105.12.2.сум дундын отрын нөөц бэлчээрт аймгийн Засаг дарга;

105.12.3.сумын отрын нөөц бэлчээрт болон нүүдэллэн оторлох бэлчээрт сумын Засаг дарга.

105.13.Улсын чанартай дамжин өнгөрөх бэлчээрийн байршил, хэмжээ, хил заагийг мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн байршилтай уялдуулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газар тогтооно.

105.14.Орон нутгийн чанартай дамжин өнгөрөх бэлчээрийн хэмжээ, хилийн цэсийг мал тууврын замын чиглэлтэй уялдуулж, харьяалах сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал болон газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

105.15.Бэлчээрийг ашиглах, хамгаалах нийтлэг журмыг газрын болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран боловсруулж Засгийн газар батална.

105.16.Энэ хуулийн 123.14-т заасан журмын хүрээнд орон нутгийн байгаль, газарзүйн нөхцөл, бэлчээр ашиглалтын уламжлалт онцлогт нийцүүлэн аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрийн харьялах нутаг дэвсгэрийн хүрээнд Бэлчээр ашиглах, хамгаалах, хяналт тавих журмыг батлан мөрдүүлнэ.

105.17.Улсын чанартай дамжин өнгөрөх бэлчээр, отрын нөөц бэлчээрийг ашиглах хамгаалах асуудлыг энэ хуулийн 123.14-т, аймаг, сумын чанартай дамжин өнгөрөх бэлчээр, отрын нөөц бэлчээрийг ашиглах хамгаалах асуудлыг энэ хуулийн 123.15-т заасан журмын дагуу зохицуулна.

105.18.Нийтээр ашиглах бэлчээрийг ашиглуулах, сайжруулах, хамгаалахтай холбоотой үйл ажиллагааг харьяалах нутаг дэвсгэрт сум, дүүргийн Засаг дарга, гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах үйл ажиллагааг бэлчээр ашиглагч нар тус тус хариуцна.

105.19.Гэрээгээр ашиглуулахаар заасан бэлчээрийг газар ашиглах гэрээний дагуу хот айл, малчдын бүлэг, холбоо, нөхөрлөлд болзол, гэрээний дагуу ашиглуулна.

105.20.Эрчимжсэн мал аж ахуй эрхлэхээс бусад тохиолдолд гадаадын иргэн, харьяалалгүй хүнд бэлчээрийг гэрээгээр ашиглуулахыг хориглоно.

105.21.Бэлчээр ашиглалтын гэрээний нийтлэг загварыг газрын болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

105.22.Газрын мониторингийн үр дүнгээр бэлчээрийн төлөв байдал, чанар, даац багтаамжийн мэдээлэлд үндэслэн бэлчээр ашиглуулах гэрээг байгуулах, сунгах ажлыг аймгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

105.23.Нүүдлийн уламжлалт мал аж ахуйн хүрээнд хууль, бодлого, аж ахуй, соёл, ёс заншлаар нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, малчдын өөр хоорондын уламжлалт харилцаанд суурилсан газар, байгалийн нөөц баялгийг нийтээр эзэмшин ашиглах жам ёсны эрхтэй байна. Малчид жам ёсны эрхээ хэрэгжүүлэх асуудлыг энэ хууль болон байгаль орчныг хамгаалах тухай, хууль тогтоомжид нийцүүлэн бэлчээр ашиглалтын гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ.

105.24.Бэлчээр ашиглагч дараах нийтлэг эрх эдэлнэ:

105.24.1.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг бусад этгээд зөвшөөрөлгүй, дур мэдэн ашигласан тохиолдолд уг үйлдлийг зогсоохыг шаардах,

105.24.2.шаардлага биелүүлээгүй тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах;

105.24.3.бэлчээрт учруулсан аливаа хохирлыг тогтоолгох, нөхөн төлүүлэх;

105.24.4.малчдын бүлэгт орох, малчдын бүлгээс гарах;

105.24.5.бэлчээрийг гэрээний дагуу ашиглах;

105.24.6.давагдашгүй хүчин зүйлийн улмаас бусдын гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт эрх бүхий этгээдээс баталсан хуваарийн дагуу мал оруулах, гаргах.

105.25.Бэлчээр ашиглагч дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

105.25.1.гэрээнд заасан үүргээ биелүүлэх;

105.25.2.бэлчээрийн даацад малын тоог нийцүүлэх;

105.25.3.бэлчээр ашигласны төлбөрийг төлөх;

105.25.4.бэлчээрийн даацаас шалтгаалан малын тоог бууруулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд үе шаттай шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

105.25.5.эрх бүхий этгээдээс баталсан бэлчээр сэлгэх, өнжөөх, улирлаар нүүх хугацааг мөрдөх;

105.25.6.өвөлжөө, хаваржааны бэлчээрт зун, намрын улиралд мал оруулахгүй хамгаалах, бэлчээрийг арчлан тордох;

105.25.7.уламжлалт мал аж ахуй эрхлэх зориулалттай бэлчээрийн хилийн зааг, дамжин болон дайран өнгөрөх нүүдлийн зам, зэрлэг ан, амьтны шилжилт хөдөлгөөнд саад учруулж хашихгүй, суваг, шуудуу ухахгүй байх;

105.25.8.хөрш болон саахалт малчдын бүлэг, бусад малчин өрхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

105.25.9.өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас бэлчээрт учруулсан хохирлыг нөхөн төлөх;

105.25.10.бэлчээрийн хөрсийг эвдэхгүй, бэлчээрийн хөрс, усыг бохирдуулахгүй, хог хаягдал хаяхгүй байх;

105.25.11.Бэлчээрт авто зам гаргахгүй байх.

105.26.Бэлчээр ашиглалтын гэрээний биелэлтийг бэлчээрийн төлөв байдал, даац, багтаамжийн талаарх газрын мониторингийн мэдээлэлд үндэслэн жил бүр дүгнэнэ.

105.27.Бэлчээр ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа, эсхүл ноцтой зөрчсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн нь тогтоогдвол бэлчээр ашиглагчтай байгуулсан гэрээг цуцлах, дуусгавар болгох асуудлыг сум, дүүргийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ.

156.28.Бэлчээр ашиглагч нь гэрээгээр заасан үүргээ биелүүлээгүй бол бэлчээрийн даацаас хэтэрсэн нийт малын зах зээлийн үнэлгээтэй дүйцэхүйц хэмжээгээр учирсан хохирлыг төлүүлнэ.

105.29.Доройтолд орсон, зэлүүд ашиглалтгүй байгаа бэлчээрт хөрөнгө оруулалт хийж ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн, өмнөх төлөв байдлыг сайжруулсан бэлчээр ашиглагчид тухайн бэлчээрийг давуу эрхтэйгээр гэрээгээр ашиглуулж болно.

105.30.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бэлчээрийг ашиглах, хамгаалах талаар дараах арга хэмжээг зохион байгуулна:

105.30.1.Бэлчээрийг улирлын хуваарьтай ашиглах, сэлгэх, отор нүүдэл хийх сар, улирлын хуваарийг тухайн жилийн ургац, экологийн чадавхыг үндэслэн бэлчээр ашиглагчдын оролцоотойгоор төлөвлөж сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусган иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

105.30.2.Бэлчээр, хадлангийн газрын ерөнхий хил зааг тогтоох, ашиглалт, хамгаалалтыг зохицуулсан тэмдэгжүүлэлт хийх ажлыг зохион байгуулах;

105.30.3.Бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал чанарын хянан баталгааны дүгнэлт зөвлөмжийг удирдамж болгон газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

105.30.4.отор, нүүдэл хийх, гэрээгээр ашиглаж буй нийтээр ашиглах бэлчээрийг дамжин өнгөрөх тогтоох нутаг бэлчээр, бусад ангиллын газар, зам маршрут, цаг хугацааг тогтоож хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

105.30.5.цөлжилтөөс сэргийлэх, бэлчээрийг сэлгэх, өнжөөж амраах, ашиглалтаас чөлөөлөх, бэлчээрт мод бут сөөг, олон наст ургамал тарих, бууцаар бордох, хашиж хамгаалах ажлыг зохион байгуулах;

105.30.6.хүрч ашиглахад хүндрэлтэй болон алсын отрын бэлчээрийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, булаг шандын эх хаших, энгийн усан сан, хөв далан байгуулах ажлыг зохион байгуулах;

105.30.7.сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгагдсан бэлчээр, хадлангийн газар болон байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлэх, байгалийн бусад баялгийг ашиглах, биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх, бэлчээрт худаг гаргах, засварлах, усжуулах, зам, даваа засах, гүүр, гарч хөв далан барих зэрэг хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх.

105.31.Гамшиг, аюулт үзэгдэл болсон тохиолдолд малчдын гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт бусдын мал оруулах, тууварлах асуудлыг гэрээний онцгой нөхцөлд тусгах бөгөөд мал тууварлах чиглэлийг тухайн шатны Засаг дарга тогтооно.

105.32.Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарсан тохиолдолд тухайн шатны Засаг дарга нар уг асуудлыг хамтран шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд онцгой байдлын комисс шийдвэрлэнэ.

105.33.Энэ хуулийн 121.29-д заасны дагуу шийдвэрлэж чадаагүй бол уг асуудлыг дээд шатны Засаг дарга, Засгийн газар шийдвэрлэнэ.

105.34.Бэлчээр ашиглахтай холбоотой маргааныг баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал шийдвэр гаргаж чадаагүй тохиолдолд уг асуудлыг сумын Засаг дарга хянан үзэж шийдвэрлэх ажлыг зохион байгуулна. Маргаан шийдвэрлэгдээгүй тохиолдолд шүүх эцсийн шийдвэр гаргана.

105.35.Ашигт малтмалын хайгуул, ашиглалттай холбоотойгоор бусдын гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, хадлангийн талбайд хохирол учруулбал тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хохирлыг нөхөн төлнө.

105.36.Газар тариалангийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалж бусдын гэрээгээр ашиглаж, эзэмшиж байгаа бэлчээр, хадлангийн талбайд учруулсан хохирлыг тэргүүн ээлжид тухайн үйлдвэрлэл эрхлэгч нөхөн төлнө.

105.37.Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад шалтгаанаар бусдын гэрээгээр ашиглаж, эзэмшиж байгаа бэлчээр, хадлангийн талбайд түймэр гарч, хохирол учруулбал буруутай этгээд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамаарч хохирлыг нөхөн төлнө.

105.38.Нийтээр ашиглах болон отрын бэлчээрийг ашиглах журам зөрчсөний улмаас учруулсан хохирлыг буруутай этгээд нөхөн төлнө.

105.39.Бусдын гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг дайран өнгөрөхдөө учруулсан хохирлыг буруутай этгээд нөхөн төлнө.

105.40.Нийтээр ашиглуулахаар заасан бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулахыг хориглоно.

105.41.Нийтээр ашиглуулах бэлчээрт өвөлжөө, хаваржаа, хашаа саравч, барилга байгууламж барихыг хориглоно.

105.42.Бэлчээрт авто зам гаргах, бэлчээрийн хөрсийг эвдэх, бохирдуулах, бусад байдлаар бэлчээрийн төлөв байдлыг алдагдуулах болон цөл, цөлөрхөг хээрийн бүсэд, эсхүл хөрсний эвдрэл, цөлжилт үүсэх эрсдэл бүхий бэлчээрт ургамал түүх, хадлан бэлтгэхийг хориглоно.

106 дугаар зүйл.Хадлангийн талбайг зохистой ашиглах, хамгаалах

106.1.Хадлангийн газрыг ашиглах, хамгаалах асуудлыг газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжүүлнэ.

106.2.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөг үндэслэн улсын тэжээлийн сангийн хадлангийн талбайг улсын тусгай хэрэгцээнд авна.

106.3.Аймаг, сум, багийн тэжээлийн сангийн хадлангийн талбайг аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр тогтоож, газрын нэгдмэл санд бүртгэнэ.

106.4.Сумын Засаг дарга жил бүр баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, сум, дүүргийн Засаг даргын санал, аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн хадлан авах бололцоотой талбайг иргэн, хуулийн этгээдэд ашиглуулах зорилгоор хуваарилж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

106.5.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газрын нэгдмэл санд бүртгэлтэй хадлангийн талбайг иргэн, хуулийн этгээдэд газрын узуфруктаар эзэмшүүлнэ.

106.6.Жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хадлан авч дуусах хүртэлх хугацаанд хадлангийн талбайд мал бэлчээхийг хориглоно.

106.7.Иргэн, хуулийн этгээд сум, дүүргийн Засаг даргатай тохиролцон бэлчээрийн ургацтай хэсгийг хадлангийн талбай болгон ашиглаж болох бөгөөд энэ нь газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн газарт хамаарахгүй.

106.8.Хадлангийн талбайг усалгаатай болгох, хашиж хамгаалах, бордох, ойн зурвас байгуулах зэргээр өөрийн хүч, хөрөнгөөр сайжруулалт хийж, ургацыг нь тогтвортой дээшлүүлсэн малчин өрх, хуулийн этгээдэд уг талбайг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн сумын Засаг дарга газрын узуфрукт олгоно.

106.9.Шинээр бий болгосон хадлангийн талбайг газрын нэгдмэл сангийн дэд ангилалд бүртгэнэ.

107 дугаар зүйл.Тариалангийн газрыг зохистой ашиглах, хамгаалах

107.1.Тариаланд тохиромжтой атар газрын тодорхой хэсгийг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

107.2.Тариаланд тохиромжтой улсын нөөц газраас шинээр тариалангийн газар бий болгох асуудлыг улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

108.7.Тариаланд шилжүүлэх атар газрыг аймаг, нийслэл, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгана.

107.4.Атар газрыг тариаланд шилжүүлэх асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

107.5.Тариалангийн талбайн захаас гадагш 500 метр хүртэлх зайд мал бэлчээх, оторлох болон бэлчээрийн мал аж ахуйн өвөлжөө, зуслан, намаржаа болгон ашиглахыг хориглоно. Хориглох зурвасын хил заагийг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр тогтооно.

107.6.Тариалангийн бүс доторх бэлчээрийг 11 дүгээр сарын 15-наас дараа оны 3 дугаар сарын 15 хүртэл хугацаанд ашиглана.

107.7.Тариалангийн бүс нутагт тариалангийн зориулалтаар газрын узуфруктыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэн газрын биржээр дамжуулан олгоно.

107.8.Тариалангийн бүс нутагт хамаарах бэлчээр, хадлангийн газрыг эрчимжсэн мал, амьтны аж ахуй эрхлэгч түр газар ашиглах гэрээгээр ашиглах давуу эрхтэй байна.

107.9.Узуфрукт эзэмшигч этгээд нь тариалангийн газрыг зүй зохистой ашиглах зорилгоор хөрс хамгаалах, ээлжлэн тариалалтын систем, усжуулалтын арга хэмжээ нэвтрүүлэх, бордох зэрэг техник технологи нэвтрүүлэх үүрэгтэй. Энэ үүргийг тариалангийн газрын узуфруктын гэрээнд тусгана.

107.10.Тариалангийн газрын ашиглалт, хамгаалалтыг ургамлын аж ахуй, таримлын төрлөөр ангилж газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааны дүгнэлт гаргана.

107.11.Тариалангийн газрын узуфрукт эзэмшигч этгээд нь газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгааг хуульд заасан хугацаа, журмын дагуу өөрийн хөрөнгөөр хийлгэнэ.

107.12.Тариалангийн газрын хөрсний үржил шимийг бууруулсан, хордуулж бохирдуулсан, бусад хэлбэрээр доройтуулсан нь газрын төлөв байдал, чанарын мониторинг, хянан баталгаагаар тогтоогдсон тохиолдолд газарт учруулсан хохирлыг гэм буруутай этгээд нөхөн төлнө.

108 дугаар зүйл.Ойн сан бүхий газрын газар зохион байгуулалт, газрын харилцаа

108.1.Ойн сан бүхий газрын хил заагийг энэ хууль, Ойн тухай хуульд заасны дагуу тогтооно.

108.2.Хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан ойн санг доор дурдсанаар ангилна:

108.2.1.хамгаалалтын бүсийн ой;

108.2.2.ашиглалтын бүсийн ой.

108.3.Ой бүхий газар, таримал ой, бут, сөөг, мод бэлтгэсэн, ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн цоорхой, түүнчлэн ойн захаас гадагш 100 метр газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай нь ойн сан бүхий газарт хамаарна.

108.4.Ойн сан бүхий газрын хил заагийг газрын нэгдмэл сангийн тооллого бүртгэлийн ажлаар тогтоож, газрын удирдлагын нэгдсэн системд бүртгэнэ.

108.5.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн ойн ашиглалтын бүсийн тодорхой хэсгийг тогтоосон хугацаа, нөхцөл, болзол, гэрээний дагуу, газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусган ойн нөхөрлөл, хуулийн этгээд газрыг газар ашиглах гэрээгээр ашиглана.

108.6.Ойн нөхөрлөл, хуулийн этгээдэд гэрээгээр эзэмшүүлж ашиглуулахаар олгосон ойн сангийн доорх газрыг газрын эрхийн улсын бүртгэлд бүртгэнэ.

108.7.Ойн сан бүхий газрыг бүртгэх, ашиглах, хамгаалах журмыг газрын асуудал эрхэлсэн болон, ойн сангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

108.8.Ойн сан бүхий газрыг ойн аж ахуй, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, геологи хайгуул, батлан хамгаалах зэрэг зориулалтаар энэ хуульд заасны дагуу бусдын эзэмшилд олгохдоо газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийнэ.

108.9.Ойн сан бүхий газрын үнэлгээг ойн төлөв байдал, чанар, ойн экосистемийн үйлчилгээнд үндэслэн тогтооно.

108.10.Ойн сан бүхий газарт ойн аж ахуй, хөдөө аж ахуйгаас бусад зориулалтаар газар ашиглаж ойн сангийн газрын төлөв байдал, чанарт хохирол учруулсан гэм буруутай этгээд хохирлыг барагдуулж нөхөн төлбөр төлнө.

108.11.Хамгаалалтын бүсийн ойд зам, гүүр барих, ус, эрчим хүч, харилцаа холбооны шугам татах, түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн

өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

109 дүгээр зүйл. Усны сан бүхий газрын газар зохион байгуулалт, газрын харилцаа

109.1. Усны сан бүхий газар, түүний онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг энэ хууль болон усны тухай хууль тогтоомжид заасны дагуу тогтоож, бүртгэнэ.

109.2. Ус болон газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, улсын газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөг үндэслэн усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, хүн амын ус хангамжийн аюулгүй байдлыг хангах зориулалтын газрыг улсын тусгай хэрэгцээнд авна.

109.3. Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтооно.

109.4. Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтооно.

109.5. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмыг газрын асуудал эрхэлсэн болон, усны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

109.6. Рашааны эргэн тойрны газарт эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийг дараах хэмжээгээр тогтооно:

109.6.1. рашааны орд, эх булгийн эргэн тойронд 100 метрийн зайд эрүүл ахуйн бүсийг;

109.6.2. эрүүл ахуйн бүсээс 200 метрээс доошгүй зайд хамгаалалтын бүсийг.

109.7. Рашааны эрүүл ахуйн бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

109.7.1. рашаан шууд авч ашиглахаас өөр зориулалтаар барилга байгууламж барих, тоног төхөөрөмж суурилуулах;

109.7.2. хог хаягдал хаях, химийн бодис хадгалах.

109.8. Рашааны хориглолтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

109.8.1. рашааныг ашиглах зориулалттай барилга байгууламжийг хаягдал ус цэвэрлэх, зайлуулах байгууламжгүй барих;

109.8.2. газар тариалан эрхлэх, мал бэлчээрлүүлэх, хадлан бэлтгэх;

109.8.3. хог хаягдал хаях, хадгалах, бохирын цооног байгуулах.

109.9. рашааны хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

109.9.1. ус, рашаан ашиглахтай шууд холбоогүй барилга байгууламж барих;

109.9.2. хог хаягдлын болон хаягдал ус зайлуулах байгууламж, цэг байрлуулах, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис хадгалах.

109.10.Хот, тосгон, бусад суурины газарт хамаарах усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалтын, эрүүл ахуйн бүсийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг харгалзан усны болон газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

109.11.Усны тухай хууль тогтоомжид заасан үндсэн шаардлагын хүрээнд тухайн газрын онцлогт нийцсэн усны сан бүхий газар, түүний хамгаалалтын зурвас газар болон газар ашиглах, хамгаалах тусгай шаардлага, журмыг усны болон газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

109.12.Усны сан бүхий газрыг хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний усаар хангах барилга байгууламж барьж ашиглах, эрүүл мэнд, спорт, аж үйлдвэр, усны аж ахуй, хөдөө аж ахуй, загасны аж ахуй, агнуурын аж ахуй, сэргээгдэх эрчим хүч, зам тээвэр, байгаль хамгаалал, бусад хэрэгцээг хангах зорилгоор ашиглана

109.13.Усны сан бүхий газарт хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасны аж ахуй, агнуурын аж ахуйн хэрэгцээ болон эрчим хүч, бусад объектыг байршуулах нэгж талбар үүсгэхдээ нэгж талбарын зориулалтыг өөрчлөхгүйгээр түр хугацаагаар гэрээгээр ашиглуулж болно.

109.14.Усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтыг энэ хууль болон усны тухай хууль тогтоомжын дагуу хэрэгжүүлнэ.

109.15.Усны сан бүхий газрыг улсын тусгай хэрэгцээ, улсын нөөц газарт улс, орон нутгийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн нэг ангиллаас нөгөө ангилалд шилжүүлж болно.

110 дугаар зүйл.Хот, тосгон, бусад суурины газрыг зохион байгуулах, зохистой ашиглах, хамгаалах

110.1.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хот, тосгон, бусад суурины газарт хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үүргийн бүсчлэл, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр тогтоосон зориулалтад нийцүүлэн газрыг эрхээр шилжүүлэх схемийг боловсруулна.

110.2.Схемийг боловсруулах тэргүүн ээлжинд зам, инженерийн байгууламж, шугам сүлжээний байршлын схем, нутаг дэвсгэрийн кадастрын хуваарийг холбогдох норм дүрэм, тавигдах шаардлагын дагуу тогтооно. Зам, инженерийн байгууламж, шугам сүлжээний байршлын схем, нутаг дэвсгэрийн кадастрын хуваарь бүхий газарт хот төлөвлөлт, дахин төлөвлөлт, барилгажилтын зураг төслийг боловсруулж хэрэгжүүлнэ.

110.3.Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй хот, тосгон, бусад сууринд газрыг бусдын эзэмшилд шилжүүлэх ажлыг тухайн шатны газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөг үндэслэн энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

110.4.Хот, тосгон, бусад суурины нутаг дэвсгэрт газрыг бусдад шилжүүлэхэд дэд бүтцийн хангамж, хөгжлийн чиглэл, ариун цэвэр, эрүүл ахуй, экологи, галын аюулгүй байдлын шаардлага, газар зохион байгуулалт, хот байгуулалтын төлөвлөгөөг үндэслэнэ.

110.5.Хот, тосгон бусад суурины доторх бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоогүй газрыг тухайн шатны Засаг дарга шийдвэр гаргаж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу ашиглалтын зориулалт, ашиглаж эхлэх хугацаа бусад нөхцөл шаардлагыг бичсэн дохио, санамж тавих, хашаа, хайс татах зэргээр хамгаална.

110.6.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан газрыг эзэмших эрхийн хугацаа дууссан, зохих зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан иргэн, хуулийн этгээдэд газар чөлөөлөх тухай мэдэгдлийг өгч газар чөлөөлөх арга хэмжээг авна.

110.7.Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу нэгж талбар газрын 10 хувийг ногоон байгууламж байгуулахад зориулна.

110.8.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орчны газрыг тохижуулах, арчлах, цэвэрлэх, хамгаалах үүргийг сууц өмчлөгчдийн холбоо хэрэгжүүлнэ.

110.9.Мэргэжлийн байгууллага орчны газарт байрлаж байгаа инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар, үйлчилгээ хийхэд саад учруулахыг хориглоно.

110.10.Нийтийн эрх ашигт харшлахгүй тохиолдолд нийтийн эдэлбэр газарт түр хугацаагаар зөөврийн худалдаа, үйлчилгээний асар, киоск, зар сурталчилгааны самбар байрлуулах болон, үйлчилгээний бусад зориулалтаар газрыг түр хугацаатай гэрээгээр ашиглуулж болно.

110.11.Хот, тосгон, бусад суурины газрыг ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ, эрэлт хэрэгцээг харгалзан хот, суурины төлөвлөлт, ариун цэвэр, эрүүл ахуйн норм дүрэм, байгаль хамгаалал, нийтийн аюулгүй байдал бусад тавигдах шаардлагыг үндэслэн хот байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр тогтооно.

111 дүгээр зүйл. Зам, шугам сүлжээний газрыг зохистой ашиглах, хамгаалах

111.1.Зам, шугам сүлжээний газрыг ашиглах, хамгаалах арга хэмжээ, үйл ажиллагааг тухайн шатны газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөнд төлөвлөж хэрэгжүүлнэ.

111.2.Зам, шугам сүлжээний газрын байршил, чиг, трассын зураг төсөл, газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөө, холбогдох байгууллагын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бусдын газар дээр барилга байгууламж барих эрхээр эзэмшүүлнэ.

111.3.Хуулиар тогтоосон газар ашиглалтын тусгайлсан горим, дэглэм, шаардлага бүхий зам, шугам сүлжээний газрын хамгаалалтын бүс, зурвас газрын хил заагийг газрын удирдлагын нэгдсэн системд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгүүлэх үүрэг хүлээнэ.

111.4.Хамгаалалтын байгууламжтай хурдны авто зам, төмөр зам, дамжуулах хоолой барьж байгуулахад хүн, мал, зэрлэг амьтны гарцыг заавал гаргана.

111.5.Авто зам нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, технологийн үйл ажиллагаа явуулах, цаашид авто замыг өргөтгөх зориулалт бүхий авто замын зурвас газартай байна.

111.6.Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газрын өргөн 100 метр /замын тэнхлэгээс хоёр тийш 50 метр/, орон нутгийн чанартай авто замын зурвас газрын өргөн 60 метр /замын тэнхлэгээс хоёр тийш 30 метр/ байна.

111.7.Авто замын зурвас газарт авто замын байгууламж болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, технологийн үйл ажиллагаа явуулахаас бусад зорилгоор газар ашиглахыг хориглоно.

111.8.Авто замын зурвас газарт замын засвар, арчилгаа, өргөтгөл сайжруулалт болон түүнтэй холбоотой бусад ажил гүйцэтгэх аж ахуйн нэгжид газрыг түр ашиглуулах асуудлыг авто замын байгууламжийн өмчлөгч, эзэмшигч байгууллага тухайн шатны Засаг даргын зөвшөөрлийг авсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

111.9.Тухайн авто замын байгууламжийн болон газар нутгийн онцлогоос шалтгаалан олон улс, улсын чанартай замын хяналт тавих зурвас газрын өргөнийг, авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутаг, аж ахуйн дотоодын авто замын хяналт тавих зурвасын өргөнийг газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

111.10.Төмөр замын шугамын дагуу технологийн онцлог үйл ажиллагааг явуулах, тээврийн аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий төмөр замын зурвас газартай байна. Төмөр замын зурвас газар нь төрийн өмч байна.

111.11.Төмөр замын зурвас газрын болон аюулгүйн бүсийн дэглэм, хэмжээг хот байгуулалт, төмөр замын тээврийн аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг харгалзан Засгийн газар тогтооно.

111.12.Төмөр замын зурвас газраас гаднах аюулгүйн бүсэд газрын эрх олгох, аливаа үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аюулгүй байдлын талаар гаргасан зөвлөмж, дүгнэлтийг харгалзан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн олгоно.

111.13.Харилцаа холбооны сүлжээний зориулалт бүхий газар, орон зайг харилцаа холбооны хамгаалалтын зурвас газар гэнэ. Хамгаалалтын зурвас газар нь дараах хэмжээтэй байна:

111.14.агаарын баганат шугамаас тал бүртээ 10 метр;

111.15.кабелийн шугамаас тал бүртээ 5 метр;

111.16.Харилцаа холбооны сүлжээнд зориулан газрыг энэ хуульд заасан эрхээр олгохдоо хамгаалалтын зурвас газрын хамт олгоно.

111.17.Харилцаа холбооны хамгаалалтын зурвас газрыг барилга, гэр, хашаа барих, мод тарих зориулалтаар ашиглахыг хориглоно.

112.18.Эрчим хүч дамжуулах шугам сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна. Хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих зориулалтаар газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

111.19.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүч дамжуулах шугам сүлжээний хамгаалалтын зурвас газрын хэмжээг эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу тогтоож, газрын удирдлагын цахим системд бүртгүүлнэ.

111.20.Эрчим хүч, харилцаа холбооны шугам сүлжээний газрын ашиглалт, хамгаалалтыг аюулгүй байдал, барилгын норм, дүрмийн дагуу зохион байгуулна.

111.21.Зам, шугам сүлжээний асуудал хариуцсан төрийн болон мэргэжлийн байгууллага нь тухайн орон нутгийн захиргаатай газрын эрхийн асуудлаа зохицуулах, мэдээллийн санд бүртгүүлэх үүрэгтэй.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
ТӨРИЙН ХЯНАЛТ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

112 дугаар зүйл. Газрын нэгдмэл санд тавих төрийн хяналт

112.1. Засгийн газар, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дагуу газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.

112.2. Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомжийн дагуу байгаль орчин, газрын харилцаа, өмч, эд хөрөнгийн болон ургамал, хорио цээр, эрүүл ахуй, геологи, уул уурхайн чиглэлийн мэргэжлийн хяналтын байгууллага, албан тушаалтнууд чиг үүргийнхээ дагуу хэрэгжүүлнэ.

112.3. Төрийн өмчийн газар дээр зохих зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж барих, эсхүл бусад хэлбэрээр түүнийг хууль бусаар дур мэдэн мэдэлдээ авч ашиглахыг завдаж буй болон ашиглаж буй тохиолдолд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга асуудлыг нэн даруй таслан зогсооно.

112.4. Шаардлагатай бол зохих шатны Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна.

112.5. Энэ хуульд заасан газар ашиглалтын зориулалтын бүс, хот төлөвлөлт, барилгын норм, дүрэм зөрчиж эрх бүхий этгээд газрын хязгаарлагдмал эрх олгосон, кадастрын зураг, барилгажилтын зураг төсөл үйлдсэн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллага эрхийг түдгэлзүүлж уг асуудлыг шийдвэрлүүлэхээр шүүхэд хандана.

112.6. Нийтийн ашиг сонирхлын үүднээс газрын харилцааны талаар гарсан шийдвэрт хяналт тавих, хууль бус шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээ авна.

112.7. Газар чөлөөлүүлэх, албадан нүүлгэхэд цагдаагийн байгууллага дараах үүрэгтэй:

112.7.1. хууль, гэрээнд заасан үндэслэлээр газар ашиглалтын гэрээ дуусгавар болсон, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр газрыг ашигласан бол албадан чөлөөлөх, нүүлгэх тухай Засаг даргын шийдвэрийн биелэлтийг хангах;

112.7.2. газар чөлөөлүүлэх, албадан нүүлгэхэд хүч хэрэглэсэн буюу зохион байгуулалттайгаар саатуулсан, эсэргүүцсэн бол зохих журмын дагуу арга хэмжээ авах.

113 дугаар зүйл. Улсын байцаагчийн эрх, үүрэг

113.1. Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаас гадна дараах эрх эдэлнэ:

113.1.1. иргэн, аж ахуй нэгж газрын тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;

113.1.2. хяналтад шаардагдах мэдээ, баримтыг холбогдох иргэн, хуулийн этгээдээс гаргуулах, хяналт, шалгалт хийхээр иргэн, хуулийн этгээдийн газарт нэвтрэн орох, сорьц, дээж авах;

113.1.3. хууль тогтоомж, технологийн зөрчил гаргаж байгаль орчинд хохирол учруулсан хуулийн этгээдийн лиценз, зөвшөөрөл, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгуулах, үйл ажиллагааг түр

болон бүрмөсөн зогсоох саналаа тухайн эрх олгосон байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

113.1.4.газарт учруулсан хохирлын хэмжээ, үнэлгээг тогтоож, дүгнэлт гаргах;

113.1.5.хууль тогтоомж зөрчиж газарт хохирол учруулсан иргэн, аж ахуй нэгжээс уг зөрчлийг арилгахыг шаардах, зөрчлийг арилгах хүртэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг нь түр зогсоох;

113.1.6.зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авах;

113.1.7.газрын тухай хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж, шийдвэрлүүлэх.

113.2.Улсын байцаагч дараах үүрэг хүлээнэ:

113.2.1.газрын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх;

113.2.2.илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нууцыг хадгалах;

113.2.3.газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах.

114 дүгээр зүйл.Газрын нэгдмэл санд тавих хөндлөнгийн хяналт

114.1.Олон нийт болон иргэний нийгмийн байгууллага газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, газар зохион байгуулалтын ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавина.

114.2.Иргэн, төрийн бус байгууллага газрын харилцаа, газар зохион байгуулалтын ажиллагаа явуулж буй байгууллага, албан тушаалтнаас гаргах гэж буй шийдвэрийн талаар мэдээлэл авах, танилцах эрхтэй.

114.3.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх хүсэлт гаргасан иргэний нийгмийн байгууллагыг бүртгэж, хамтран ажиллана.

114.4.Хөндлөнгийн хяналт хэрэгжүүлсэн иргэний нийгмийн байгууллага нь газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайлангаа тухай бүр хүргүүлэх бөгөөд уг тайлангийн мөрөөр арга хэмжээ авч, иргэний нийгмийн байгууллага болон нийтэд мэдээлнэ.

115 дугаар зүйл.Газартай холбогдон үүссэн маргааныг хянан шийдвэрлэх

115.1.Газрын харилцаатай холбогдон үүссэн маргааныг доор дурдсан байгууллага, албан тушаалтан дараах журмаар шийдвэрлэнэ:

115.1.1.сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хил заагийн талаарх маргааныг аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн байгууллагын даргаар ахлуулж, аймгийн газрын албаны кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн, холбогдох сум, дүүргийн Засаг дарга, дүүргийн газрын албаны мэргэжилтэн, сумын газрын даамал,

мэргэжлийн холбогдох байгууллага, иргэдийн төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр байгуулж, хянан шийдвэрлэнэ.

115.1.2.аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хил заагийн талаарх маргааныг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар ахлуулж холбогдох аймаг, сумын болон нийслэлийн удирдлага, газрын албаны дарга, мэргэжилтэн, мэргэжлийн холбогдох байгууллага, иргэдийн төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг Засгийн газрын шийдвэрээр байгуулж хянан шийдвэрлэнэ.

115.1.3.энэ хуулийн 115.1.1, 115.1.2 зааснаас бусад маргааныг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх газрын маргаан таслах орон тооны бус зөвлөл шийдвэрлэнэ.

116 дугаар зүйл.Маргаан таслах зөвлөл

116.1.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд иргэн, хуулийн этгээдээс газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдуулан гаргасан гомдолыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий газрын маргаан таслах орон тооны бус зөвлөл /цаашид “маргаан таслах зөвлөл” гэх/ ажиллана.

116.2.Маргаан таслах зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон дарга, нарийн бичгийн даргыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

116.3.Маргаан таслах зөвлөлийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллага, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан 9, эсхүл 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Маргаан таслах зөвлөлийн ажиллах журмыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

117 дугаар зүйл. Маргаан таслах зөвлөлд гомдол гаргах, шийдвэрлэх

117.1.Иргэн, хуулийн этгээд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулахтай холбоотой тухайн шатны Засаг дарга болон аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, дүүргийн газрын алба, сумын даамлын гаргасан шийдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрөхгүй бол уг шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор маргаан таслах зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

117.2.Гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

117.3.Маргаан таслах зөвлөлийн хуралдааныг бүх гишүүний гуравны хоёр нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно. Маргаан таслах зөвлөл нь гомдлыг хуралдаанаараа хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

117.4.Маргаан таслах зөвлөл нь тухайн шатны Засаг дарга болон аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, дүүргийн

газрын алба, сумын даамлын шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, хэвээр үлдээх шийдвэрийн аль нэгийг гаргах бөгөөд уг шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

117.5.Маргаан таслах зөвлөл нь маргаан үүссэн шалтгаан, түүний нөхцөлийг арилгуулах, газрын тухай хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж гаргаж, холбогдох шатны Засаг дарга болон аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, дүүргийн газрын алба, сумын даамалд хүргүүлэх эрхтэй.

117.6.Маргаан таслах зөвлөл нь иргэн, хуулийн этгээдийн гомдол гаргаснаас хойш 30 хоногийн дотор гомдол болон түүний дагалдах баримт бичиг, мэдээллийг хянан шийдвэрлэж, уг шийдвэрийг маргааны оролцогч талуудад гардуулна.

117.7.Маргаан таслах зөвлөлийн тогтоолыг тухайн шатны Засаг дарга болон аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, дүүргийн газрын алба, сумын даамал гардан авснаас хойш 30 хоногийн дотор холбогдох шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох үүрэг хүлээнэ.

117.8.Маргаан таслах зөвлөл нь энэ хуулийн 117.7-д заасан шийдвэр гаргах хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

117.9.Маргаан таслах зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвхөн шүүхийн шийдвэрээр өөрчилнө.

117.10.Иргэн, хуулийн этгээд нь маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд хандах эрхтэй.

117.11. Гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, гомдлын нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай, нэмж тодруулах зүйлийн цар хүрээ нь маргаан таслах зөвлөлийн магадлан судлах боломжоос хэтэрсэн, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.3-т заасантай адилтгах шалтгаанаар маргаан таслах зөвлөл иргэн, хуулийн этгээдийн гомдлыг хянан шийдвэрлэх боломжгүй бол гомдол гаргагчид 3 хоногийн дотор буцаана.

118 дугаар зүйл.Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох

118.1.Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газрын эрхтэй этгээд, газар ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг шийдвэр /эс үйлдэхүй/-ийг тухайн байгууллага, албан тушаалтан өөрөө цуцлах, эсхүл түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан хүчингүй болгоно. Шийдвэрийг өөрөө цуцлаагүй эсхүл түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан хүчингүй болгоогүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

118.2.Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль зөрчсөн шийдвэрийн дагуу газар ашиглаж буй этгээдийн үйл ажиллагааг цагдаагийн байгууллага таслан зогсоож, газрыг албадан чөлөөлнө.

119 дугаар зүйл.Хохирлыг нөхөн төлүүлэх

119.1.Газрыг доройтуулсан, эсхүл бохирдуулж хохирол учруулсан гэм буруутай этгээд нь Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран уг хохирлыг өөрийн хөрөнгөөр арилгах арга хэмжээ авах бөгөөд хэрэв мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бол үүнтэй холбогдон гарсан зардлыг бүрэн хариуцна.

119.2.Газарт учирсан хохирлыг тооцох журмыг газрын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

120 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

120.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

120.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, аж ахуй нэгжид Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

120.3.Газрын тухай хууль зөрчигчид торгууль оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

121 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

121.1.Энэ хуулийг 2021 оны ... дүгээр сарын...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.